

МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ ТҮҮВЭР СУДАЛГАА-2005

1. Оршил

Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар МУИС-ийн Социологийн тэнхимтэй хамтран Монгол Улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтийн дунд 2005 онд санал асуулга явуулж, 2003 оны мөн үеийнхээс хэр өөрчлөгдсөнийг харьцуулан дүн шинжилгээ хийснээ та бүхэнд толилуулж байна. Энэ жилийн судалгааны ажлын онцлог бол өмнөх онуудын суурь дээр тулгуурлан иргэдийн санал бодол 2003 оныхоос хэр өөрчлөгдсөнийг харуулсны зэрэгцээ судалгаанд оролцсон иргэдийг аймаг хот, нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлаар нь ангилан тус бүрээр нь тайлбар хийсэнд оршино. Мөн манай улсад сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж буй бичил санхүүгийн талаар тусгай бүлэг болгон оруулж судалгаа хийсэн болно.

2005 оны 8 дугаар сарын байдлаар мөнгөний нийлүүлэлтийн (M2) хэмжээ 1081.2 тэрбум төгрөг; инфляцийн түвшин оны эхнээс 10.0 хувь, сүүлийн 12 сарын байдлаар 11.7 хувь; банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн өрийн үлдэгдэл 768.8 орчим тэрбум төгрөг; нийт хадгаламжийн хэмжээ 618.9 тэрбум төгрөг; нэгдсэн төсвийн алдагдал эерэг 67.0 тэрбум төгрөг; улсын гадаад цэвэр албан нөөц 244.5 сая америк доллар; Монгол улсын гадаад худалдааны алдагдал 150.6 сая америк доллар байна.

Олон улсын статистикийн лавлахууд дээр гарсан тоон үзүүлэлтүүдээс харахад: 2004 оны байдлаар Монгол улсын хүн амын 36.3 хувь нь ядуурлын түвшинд (Human development report 2005, UNDP), хүний ядуурлын индексээр авч үзвэл дэлхийн улсуудын 44-т, нийгмийн орлогын (баялаг) 69.7 хувь нь тэгш бус хуваарилагддаг, хүн амын 27.0 хувь нь өдрийн 1 америк доллароос доогуур орлоготой (Key indicators 2003, ADB); Хүний хөгжлийн түвшинг харуулсан индекс 2003 оны байдлаар 0.679 буюу дэлхийн улсуудын 114-т (Human development report 2005, UNDP); 2002-2003 онд хүн амын өсөлт 1.2 хувь, 2002 оны байдлаар ажиллах насанд хүрсэн иргэдийг хүйсээр нь ангиллаж үзвэл эрэгтэйчүүдийн 60.5 хувь, эмэгтэйчүүдийн 64.9 хувь нь эдийн засгийн идэвхтэй байдалд байна.

Энэ судалгааны ажлыг 2002, 2003 онуудад зохион байгуулсан бөгөөд зохих үр дүнгээ өгч, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдан танилцуулагдсан болно. Энэ жилийн хувьд асуултууд нь арай оновчтой энгийн болсны зэрэгцээ өмнөх онуудтай харьцуулах боломжтой боллоо. Манай улсын хувьд зах зээлийн системд шилжин орсноос хойш чамлахааргүй ололт амжилт гарч байгаа хэдий ч хүн амын ядуурал дорвитой буураагүй, иргэдийн орлогын өсөлт доогуур, ажилгүйчүүдийн түвшин өндөр, ДНБ-ий дундаж өсөлт тогтмол биш, гадаад өрийн хэмжээ их зэрэг нь сэтгэл зовоосон асуудал хэвээр байна. Дээр өгүүлсэн ололт амжилт, хүндрэл бэрхшээлүүдийн талаар иргэдийн санал бодлыг сонсох нь цаашид ололтоо яаж бататгах, бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэхэд тус дөхөм

болно гэдэгт бид эргэлзэхгүй байна. Монголбанкны удирдлагын зүгээс нийгэм, эдийн засгийн, банк санхүүгийн салбарын тулгамдсан асуудлаар иргэдийн дунд санал асуулга явуулж, нэгтгэн дүгнэн, цаашдын бодлого боловсруулалт болон үйл ажиллагаандаа ашигладаг. Одоо та бүхэнд 2005 оны санал асуулгын дүнг толилуулъя.

2. Судалгааны ажлын үндсэн зорилт

2.1. Судалгааны ажлын зорилго

Судалгааны ажлын зорилго нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн ерөнхий байдал, татварын тогтолцоо, банк санхүүгийн салбарын хөгжил, банкны хадгаламж, зээл болон бичил санхүүгийн талаар жирийн иргэдийн дунд товч санал асуулга явуулж, нэгтгэн дүгнэж 2003 оны мөн үеийнхтэй харьцуулахад оршино. Түүний зэрэгцээ судалгаанд оролцсон иргэдийг нас, хүйс, харьяалал, боловсрол, ажил эрхлэлтийн байдлаар нь бүлэглэн дүнг тус бүрээр нь нэгтгэн харуулахыг зорилоо. Санал асуулгын дүнг үндэслэн Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш өнөөг хүртэлх хугацаанд нийгэм эдийн засаг ялангуяа банк санхүүгийн салбарын хөгжлийг дүгнэж цаашдын чиг хандлагыг тодорхойлохыг зорьж байна.

2.2. Судалгааны ажлын хамрах хүрээ, хугацаа

Түүвэр судалгааг манай улсын эдийн засгийн том төвүүд болон орон нутгийн дийлэнхийг хамруулан 2005 оны 5 дугаар сарын 23-ний өдрөөс 6 дугаар сарын 13-ны өдөр хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын бүх дүүргүүд болон Орхон, Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говь-Сүмбэр, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Төв зэрэг аймгуудад явуулав.¹ Санал асуулгыг тусгай баталсан удирдамжийн дагуу МУИС-ийн социологийн тэнхим, Монголбанк гэсэн 2 багт хуваагдан дээрх хот, аймгуудад хийж гүйцэтгэлээ.

2.3. Судалгааны ажлын мэдээллийн сан

Энэ жилийн судалгаанд нийт 5405 иргэд оролцсон нь 2003 оныхоос 124 хүнээр их буюу 2.3 хувиар өссөн байна. Үүний 23.0 хувь нь Улаанбаатар хотын, 6 хувь нь Дорноговь, 5.6 хувь нь Төв, тус бүр 5.5 хувь нь Хөвсгөл, Орхон, 5.4 хувь нь Ховд, тус бүр 5.2 хувь нь Хэнтий, Говь-Алтай, тус бүр 5.1 хувь нь Баян-Өлгий, Өмнөговь, тус бүр 5.0 хувь нь Архангай, Завхан, 4.8 хувь нь Говь-Сүмбэр, 4.7 хувь нь Булган, 4.6 хувь нь Өвөрхангай, 4.4 хувь нь Сүхбаатар аймгуудын оршин суугч нар байв. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан аймгуудаас (Улаанбаатар хотоос бусад) бараг жигд асуулга авч чадсан байна. Түүний зэрэгцээ аймгийн төвүүдээс алслагдсан зарим сумдаар явж судалгаа явуулсан нь энэ жилийн бас нэг онцлог болно.

Хүснэгт 1.-ээс харахад Монгол улсын нийт хүн амын 0.21 хувь нь түүвэр судалгаанд хамрагдсанаас судалгаанд оролцсон нийт иргэдийн

¹ 2003 онд Улаанбаатар хот болон Архангай, Булган, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул аймгуудад явуулсан.

тоонд эзлэх хувиараа Улаабаатар хот хамгийн их буюу 23.0 хувь, бусад аймгууд 4.6-5.6 хувьтай оролцжээ.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо, хот аймгуудаар

		Хүн амын тоо, мянган хүн	Хувийн жин	Судалгаанд оролцсон хүн	Хүн амд эзлэх хувийн жин	Судалгаанд эзлэх хувийн жин
1	Улаанбаатар	928.5	49.1%	1243.0	0.07%	23.0%
2	Хөвсгөл	121.4	4.8%	298.0	0.25%	5.5%
3	Өвөрхангай	113.2	4.5%	250.0	0.22%	4.6%
4	Баян-Өлгий	101.2	4.0%	275.0	0.27%	5.1%
5	Сэлэнгэ	100.8	4.0%			
6	Архангай	94.9	3.7%	270.0	0.28%	5.0%
7	Төв	88.9	3.5%	303.0	0.34%	5.6%
8	Дархан	87.8	3.5%			
9	Ховд	87.8	3.5%	292.0	0.33%	5.4%
10	Баянхонгор	83.8	3.3%			
11	Увс	81.0	3.2%			
12	Завхан	80.7	3.2%	272.0	0.34%	5.0%
13	Эрдэнэт	78.4	3.1%	297.0	0.38%	5.5%
14	Дорног	73.7	2.9%			
15	Хэнтий	71.2	2.8%	281.0	0.39%	5.2%
16	Говь-Алтай	60.9	2.4%	279.0	0.46%	5.2%
17	Булган	60.8	2.4%	254.0	0.42%	4.7%
18	Сүхбаатар	56.6	2.2%	236.0	0.42%	4.4%
19	Дорноговь	52.5	2.1%	323.0	0.62%	6.0%
20	Дундговь	49.9	2.0%			
21	Өмнөговь	46.8	1.8%	275.0	0.59%	5.1%
22	Говьсүмбэр	12.4	0.5%	257.0	2.07%	4.8%
Нийт		2533.2	100.0%	5405.0	0.21%	

Судалгаанд оролцсон иргэдийн 44.0 хувь нь эрэгтэй, 56.0 хувь нь эмэгтэй байсан нь 2003 оныхоос эмэгтэйчүүдийн тоо 0.9 нэгжээр өсчээ. Насны байдлаар нь авч үзвэл 19.1 хувь нь 25-аас доош, 29.4 хувь нь 25-34, 26.3 хувь нь 35-44, 17.9 хувь нь 45-54, 5.8 хувь нь 55-64, 1.6 хувь нь 65-аас дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна. Үүнээс үзэхэд санал асуулгад 25-44 насны иргэд идэвхтэй оролцсон байна. 2003 оныхоос 25-аас доош насныхны идэвх (1.2 нэгж) өссөн бол 35-44 насныхных (2.6 нэгж) буурсан байна.

Боловсролын түвшингээр ангилбал 12.5 хувь нь бүрэн бус дунд, 30.0 хувь нь бүрэн дунд, 21.3 хувь нь тусгай дунд, 36.2 хувь нь дээд боловсролтой байлаа. Дээрхээс харахад дээд болон бүрэн дунд боловсролтой иргэд хамгийн их оролцож санал бодлоо тусгасан байна. 2003 онтой харьцуулахад бүрэн бус дунд (0.7 хувь), дээд (4.7 хувь) боловсролтой иргэдийн идэвх суларсан бол бүрэн дунд (2.3 хувь), тусгай дунд (3.1 хувь) боловсролтой иргэдийн идэвх дээшилсэн байна.

Судалгаанд оролцсон иргэдийн 29.6 хувь нь улсын, 24.7 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 20.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 16.3 хувь нь ажилгүй, 8.1 хувь нь бусад гэсэн ангилалд багтаж 0.7 хувь нь хариулаагүй байна. Улсын болон хувийн байгууллагад ажилладаг иргэд маань илүү идэвхтэй оролцсон нь санал асуулгын дүнгээс харагдаж байна.

Хувийн байгууллага, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ажилгүй болон бусад гэсэн ангилалд хамрагдсан иргэдийн хувийн жин 2003 оныхоос бага зэрэг өссөн бол улсын байгууллагад ажилладаг иргэдийнх (6.5 хувь) буурчээ.

Хүснэгт 2. Судалгаанд оролцсон иргэдийн талаархи мэдээлэл

		Хүйс		Нас		Боловсрол		Ажил эрхлэлт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хүйс	эр эм	2378 3027	44.0% 56.0%						
Нас	25 доош 25-34 35-44 45-54 55-64 65 дээш			1030 1588 1421 966 316 84	19.1% 29.4% 26.3% 17.9% 5.8% 1.6%				
Боловсрол	бүрэн бус дунд бүрэн дунд тусгай дунд дээд					677 1621 1149 1958	12.5% 30.0% 21.3% 36.2%		
Ажил эрхлэлт	улсын хувийн ХХЭрхэлдэг ажилгүй бусад							1599 1335 1109 883 439	29.6% 24.7% 20.5% 16.3% 8.1%
Хариулаагүй		0	0.0%	0	0.0%	0	0.0%	40	0.7%
Нийт		5405	100.0%	5405	100.0%	5405	100.0%	5405	100.0%

Нийтэд нь дүгнэж хэлэхэд энэхүү судалгаанд дээд боловсролтой, улсын болон хувийн байгууллагад ажилладаг, 25-45 насны, эмэгтэй иргэд түлхүү оролцсон байна.

2.4. Судалгааны ажлын бүтэц, аргачлал

Судалгааны ажил нь оршил, үндсэн зорилт, үр дүн, дүгнэлт гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэхээс гадна хавсралт I-VI-г агуулсан болно. Нэгдүгээр хэсэг буюу оршил хэсэгт Монгол улсын нийгэм эдийн засгийн сүүлийн үеийн байдлыг товч дурдсан; хоёрдугаар хэсэг буюу үндсэн хэсэгт судалгааны ажлын зорилго, хамрах хүрээ, мэдээллийн сан, бүтэц болон аргачлалын талаар дэлгэрэнгүй тайлбарласан; гуравдугаар хэсэг буюу энэ ажлын хамгийн чухал хэсэгт санал асуулгын ерөнхий дүнг нэгтгэн 2003 онтой харьцуулан дүгнэлээ. Ингэхдээ санал асуулгад тусгагдсан 38 асуултыг утга агуулгаар нь ангилан 7 дэд бүлэг болгож, нийгэм, эдийн засгийн бодит байдалтай харьцуулан асуулт бүрээр дэлгэрэнгүй тайлбар өгөв. Тухайлбал:

1. Эдийн засгийн ерөнхий асуудлууд,
2. Нийгмийн тулгамдсан асуудлууд,
3. Татварын талаар,
4. Банк санхүүгийн салбарын тулгамдсан асуудлууд,
5. Хадгаламж, хуримтлал,
6. Зээлийн талаар,
7. Бичил санхүүгийн талаар.

Дөрөвдүгээр хэсэг буюу сүүлийн хэсэгт дээр дурьдсан 7 дэд бүлгийг тус бүрээр нь нэгтгэн дүгнэж, цаашид авах арга хэмжээ, сургамжуудын талаар өгүүлсэн болно. Хавсралт I-V-д судалгаанд хамрагдсан иргэдийг орон нутгийн харьяалал, хүйс, нас, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлаар нь 6 хэсэгт бүлэглэн, бүлэг тус бүрээр нь тайлбарлан дүгнэлээ. Сүүлийн хавсралтанд (VI) иргэдийн хариултыг нэгтгэн хүснэгтэнд тоон үзүүлэлтээр болон хувьчлан тусгав.

Санал асуулгад оролцсон иргэдийн цөөн хувь нь зарим асуултанд хариулаагүй учир асуулт бүр 100 хувийн хариулт авч чадаагүй болно. Мөн зарим асуултууд давхардсан хариулттай байсан учир нийт хариулт нь 100 хувиас илүү гарсан болно.

3. Судалгааны ажлын дүн

Тухайн улсын нийгмийн байдал, эдийн засгийн хөгжлийг тодорхойлдог статистикийн олон үзүүлэлтүүд байдаг. Эдгээрийн дотор дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлт, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, хэрэглээний барааны үнийн өөрчлөлт (инфляци), гадаад худалдааны тэнцэл, банк санхүүгийн салбарын хөгжлийн тоон үзүүлэлтүүд, үндэсний валютын тогтвортой байдал, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн урсгал, гадаад өр, төсвийн алдагдал болон ажилгүйдэл, ядуурлын түвшин, татварын тогтолцоо зэрэг үзүүлэлтүүд гол үүрэг гүйцэтгэж, тухайн улсын дүр төрхийг харуулдаг байна. Энэ санал асуулга нь манай улсын нийгэм, эдийн засгийн байдал, түүний дотор банк санхүүгийн салбар зах зээлийн системд шилжиж орсноос хойш өнөөг хүртэл хэрхэн өөрчлөгдсөн, одоо ямар байдалд байгааг жирийн иргэдийн зүгээс яаж дүгнэн цэгнэж байгааг харуулахын зэрэгцээ бодит байдалтай (статистикийн тоон үзүүлэлтүүдтэй) харьцуулан дүгнэхэд чиглэгдсэн юм. Түүний зэрэгцээ иргэдийн санал бодол 2 жилийн дараа хэрхэн өөрчлөгдсөнийг харуулахыг зорилоо.

3.1. Эдийн засгийн ерөнхий асуудлууд

Санал асуулгын ерөнхий асуулт (1.1.) буюу "Монгол улсын эдийн засгийн байдал таны бодлоор ямар байна вэ?" гэсэн асуултанд нийт оролцогчдын 25.1 хувь нь сайжирч байна, 36.2 хувь нь хэвэндээ гэж үзсэн бол 30.3 хувь нь муудаж байна, 8.3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Энэ дүнг 2003 оныхтой харьцуулахад эдийн засгийн байдал сайжирч байна гэсэн үнэлгээ 12.8 хувиар буурч, нөгөө талаас муудаж байна гэсэн нь 11.7 хувиар өссөн байна. Энэ асуулт нь нийгэм эдийн засгийг хамарсан ерөнхий асуулт учраас бодит байдалтай харьцуулан тайлбарлахад их зүйл шаардагдана. Тиймээс маш товчхон хэдэн үгээр илэрхийлэхийг зорилоо. Түүний зэрэгцээ дээрх асуултын бүрэлдэхүүн хэсэг болох дэд асуултууд дараа тавигдах учраас давтахаас зайлсхийсэн болно.


Монгол улсын эдийн засгийн байдал ямар байна гэдгийг юуны түрүүнд эдийн засгийн өсөлтөөр тодорхойлж болох юм. Зураг 1.-ээс харахад зах зээлийн системд шилжин орсон эхний жилүүдэд манай улсын эдийн засаг уналтанд орж өсөлт (ДНБ-ий өсөлт) нь сөрөг түвшинд байсан бөгөөд харин

1994 оноос эхлэн 2004 он хүртэл эерэг түвшинд байна. Хэдийгээр сүүлийн 11 жилийн турш эдийн засгийн өсөлт эерэг түвшинд, 1990 оноос хойш нийт өсөлтийн нийлбэр 19.7 хувь байгаа ч жилийн дундаж өсөлт 1.3 хувь, сүүлийн 11 жилийн дундаж нь 4.0 байгаа нь зах зээлийн системд шилжин орж буй болон хөгжиж байгаа орнуудын хувьд сул үзүүлэлт юм. 2004 онд ДНБ-ий өсөлт 10.6 хувьтай гарсан нь 2003 оныхоос даруй 5.0 нэгжээр илүү байгаа бөгөөд энэ нь цаашид эдийн засгийн өсөлтийг өндөр байлгах итгэлийг төрүүлж байна.


1.1. Монгол улсын эдийн засгийн байдал таны бодлоор

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Сайжирч байна	2001	37.9%	1336	25.1%	-12.8%
Муудаж байна	984	18.6%	1612	30.3%	11.7%
Хэвэндээ	1838	34.8%	1926	36.2%	1.4%
Мэдэхгүй	458	8.7%	442	8.3%	-0.4%
Нийт	5281	100.0%	5316	100.0%	0.0%
Хариулаагүй	0	0.0%	89	1.6%	1.6%
Нийт	5281		5405		

Зураг 1. ДНБ-ий өсөлт, хувиар



Зураг 2. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам. доллар



Эдийн засгийн өсөлттэй холбогдуулан бас нэг чухал үзүүлэлтийг авч үзье. Энэ бол нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ бөгөөд уг үзүүлэлт хэдий чинээ их байх тусам тухайн улсын эдийн засаг хөгжиж хүн амын бодит орлого өндөр байна гэсэн үг юм. Монгол улсын хувьд уг үзүүлэлт 1990-2004 онуудын дундажаар 383.2 ам. доллар, 2004 оны эцсийн байдлаар 590.4 ам. доллартай тэнцэж байгаа нь хүн амын бодит орлого багатай улсуудын тоонд багтаж байна (Зураг 2.). Уг үзүүлэлт нь 1995 онд 516.6 ам. долларт хүрч байсан бол 1996-1999 онуудад доошилж 363.6 ам. долларт хүрчээ. Харин 2000 оноос эхлэн тогтмол дээшилж 2004 онд дээд цэгтээ хүрсэн байна. ДНБ-ий өсөлт сүүлийн жилүүдэд огцом өсч байгаа, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ч мөн адил дээшилж байгаа хэдий ч санал асуулгад оролцсон иргэдийн зүгээс өнөөгийн эдийн засгийн байдал 2003 оныхоос муудсан (11.7 хувиар нэмэгдсэн) гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Үүнийг дараахь хэдэн өгүүлбэрээр тайлбарлахыг оролдъё. Дэлхийн зах зээл дэх бензин шатахууны үнэ 2004 оны дундаас эхэлж огцом өссөн нь импортоор эрэлтээ хангадаг манай улсын хувьд нийлүүлэлтийн шокод орж, суурь инфляци

улмаар түүнийг даган өргөн хэрэглээний барааны үнэ харьцангуйгаар огцом өсч иргэдийн ахуй амьдралд хүнд цохилт өгсөн байж болох талтай. Түүний зэрэгцээ иргэдийн бодит орлого (цалин, тэтгэвэр г.м.) үнийн өсөлттэй уялдан дорвитой нэмэгдээгүй нь энэхүү дүгнэлтэнд хүргэсэн болно. Нөгөө талаас гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийн (ялангуяа уул уурхай, олборлох үйлдвэрүүд) үйл ажиллагааны өргөжилтийн үр дүнд ДНБ-ий өсөлт өндөр түвшинд хангагдаж, Монгол улсын иргэдийн бодит орлогод төдийлөн нөлөө үзүүлж чадахгүй байгаагийн зэрэгцээ ажиллах хүчний тоог төдийлөн нэмэгдүүлэхгүй байгаатай холбоотой болов уу. Эцэст нь эдийн засагт бүрэлдэж буй баялгийн хуваарилалтын тэгш бус байдал өсч байгаа нь (70 орчим хувь) энэ бүхэнд хүчтэй нөлөөлсөн байж болох талтай. Өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлтийн үр шимийг иргэд тэгш эрхтэйгээр хүртэж чадахгүй байна. Үүний нэг баталгаа бол ядуурал 36.0 хувиас буурахгүй байгаа явдал юм.

"Эдийн засгийн өсөлтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ ?" гэсэн асуултанд (1.2.) судалгаанд оролцогчид нэгээс илүү хариултыг сонгосон бөгөөд нийт хариултын тоо нь 9244 болсон байна.

1.2. Таны бодлоор эдийн засгийн өсөлтийг хангахын тулд

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Татвар бууруулах	2339	25.1%	2357	25.5%	0.4%
ГХО-ыг нэмэгдүүлэх	1224	13.1%	1094	11.8%	-1.3%
Зээлийн хүүг багасгах	1942	20.8%	2292	24.8%	4.0%
Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих	2770	29.7%	2617	28.3%	-1.4%
Бизнесменүүдийг дэмжих	869	9.3%	717	7.8%	-1.6%
Бусад	174	1.9%	167	1.8%	-0.1%
Нийт	9318	100.0%	9244	100.0%	0.0%
Нийт	-4037	-76.4%	-3839	-71.0%	5.4%
	5281		5405		

Иргэдийн 28.3 хувь нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, 25.5 хувь нь татварын хэмжээг бууруулах, 24.8 хувь нь зээлийн хүүг багасгах, 11.8 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, 7.8 хувь нь бизнесменүүдээ урамшуулал хөнгөлөлт үзүүлэх, 1.8 хувь нь бусад хүчин зүйлсээс хамаарч эдийн засаг өснө гэж хариулжээ. 2003 онтой харьцуулахад зээлийн хүүг бууруулах шаардлагатай байна гэж хариулсан иргэдийнх 4.0 хувиар өссөн байна. Энэ асуултанд өмнөх онуудын нэгэн адилаар иргэдийн ихэнх нь үндэсний үйлдвэрээ дэмжиж, татварын ачааллыг багасгавал эдийн засгийн өсөлтийг хангаж чадна гэж үзжээ. Түүний зэрэгцээ зээлийн хүүг бууруулах шаардлагатай гэж үзэж байна. Монголбанкны зүгээс зээлийн хүүний ерөнхий түвшинг байнга анхааралтай ажиглаж тооцоо судалгаа хийж байгаа бөгөөд банкуудын эх үүсвэрийн зардал тодорхой хэмжээгээр буурсан үед зээлийн хүү аяндаа буурна гэсэн хүлээлттэй байна. Банкны системийн татан төвлөрүүлсэн хөрөнгө их хэмжээгээр нэмэгдэж буй 2004-2005 онуудад зарим банкуудын хадгаламжийн хүү бага зэрэг буурсан боловч нийт системийн хэмжээгээр дорвитой доошилсонгүй. Түүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд их хэмжээгээр бий болж буй ББСБ, ХЗХ-ын эх үүсвэрийн төлөөх тэмцэл нь хүүний түвшинг бууруулахгүй байгааг анхаарах зохих арга хэмжээг авахаар төлөвлөж байна.

"Манай улсын ямар салбар эдийн засгийн өсөлтөнд их үүрэг гүйцэтгэх вэ?" гэсэн асуултанд (1.3.) судалгаанд оролцсон иргэд мөн нэгээс илүү хариулт өгсөн ба 23.5 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрлэл, 24.9 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 13.7 хувь нь хөдөө аж ахуй, 17.5 хувь нь аялал жуулчлал, 9.8 хувь нь банк санхүү, 8.4 хувь нь худалдаа үйлчилгээ, 2.1 хувь нь бусад салбар гэж хариулжээ. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн салбаруудын өсөлт ямар түвшинд байгаа, ДНБ-ий өсөлтөнд яаж нөлөөлж буйг дараахь хэдэн өгүүлбэрээр тайлбарлая. 2004 оны эцсийн байдлаар эдийн засгийн салбаруудын ДНБ-д эзлэх хувийг авч үзвэл: худалдаа, засварлах үйлчилгээ 26.7 хувь, ХАА, ан агнуур, ойн аж ахуй 21.3 хувь, тээвэр, агуулах, холбоо 14.3 хувь, уул уурхай, олборлох үйлдвэрлэл 12.2 хувь, боловсруулах үйлдвэрлэл 8.6 хувь, боловсрол болон санхүүгийн үйлчилгээ тус бүр 4.0 хувь, төрийн удирдлага, батлан хамгаалах, даатгал 3.1 хувь, барилга 2.9 хувь, цахилгаан, дулаан, ус 2.2 хувь, эрүүл мэнд, халамж 1.6 хувь, үл хөдлөх хөрөнгө, түрээс 1.4 хувь, зочид буудал, зоогийн газар 1.1 хувь, бусад 0.6 хувийг тус тус эзэлж байна (Хүснэгт 3.). 2001-2004 онуудын хооронд ХАА, ан агнуур, ойн аж ахуй, төрийн удирдлага, батлан хамгаалах, даатгалын салбаруудаас бусад салбаруудын дундаж өсөлт эерэг түвшинд байна.

1.3. Таны бодлоор ямар салбар эдийн засгийг түргэн хөгжүүлэх вэ

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Уул уурхай	1865	19.7%	2182	23.5%	3.9%
Боловсруулах	1149	12.1%	2311	24.9%	12.8%
Хөдөө аж ахуй	2325	24.5%	1271	13.7%	-10.8%
Аялал жуулчлал	1889	19.9%	1626	17.5%	-2.4%
Банк санхүү	1156	12.2%	912	9.8%	-2.4%
Худалдаа үйлчилгээ	841	8.9%	775	8.4%	-0.5%
Бусад	252	2.7%	194	2.1%	-0.6%
Нийт	9477	100.0%	9271	100.0%	0.0%
Нийт	-4196	-79.5%	-3866	-41.7%	37.8%
	5281		5405		

Хүснэгт 3.-аас харахад бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ нь ДНБ-ий хамгийн их буюу 26.7 хувийг эзэлж байгаа бөгөөд санал асуулгад оролцсон иргэдийн 8.4 хувь нь эдийн засгийн өсөлтийг тодорхойлно гэж үзсэн нь 2003 оныхоос бага зэрэг буюу 0.5 хувиар буурсан байна. Энэ салбарын өсөлт 2001 оноос 2004 он хүртэл эерэг, өндөр түвшинд байгаа бөгөөд иргэд маань энэ салбар эдийн засгийн өсөлтөнд багагүй хувь нэмэр оруулна гэж хариулсан хэвээр байна.

ДНБ-ий хамгийн их хувийг эзэлж байсан ХАА-н салбарын үйлдвэрлэл (2004 оны байдлаар худалдааны салбарын дараа хоёрт байгаа) сүүлийн жилүүдэд дорвитой өссөн хэдий ч 2001, 2002 онуудын ган, зуд гэх мэт байгалийн бэрхшээлүүдээс шалтгаалан сүүлийн 4 жилийн дундаж өсөлт нь сөрөг хэвээр байна. Монгол улс бол эртнээс хөдөө аж ахуйн орон. Иймээс энэ салбарын өсөлтийг дэмжихгүйгээр эдийн засаг маань дорвитой өсөхгүй нь тодорхой. 2003 онд судалгаанд оролцсон иргэдийн дөрөвний нэг орчим хувь нь ХАА-н салбар эдийн засгийн өсөлтийг тодорхойлно гэж үзэж байсан бол энэ онд тэр хувь 11 нэгжээр буурч 13.7 хувьд хүрчээ. ХАА-н

салбарт үзүүлж буй иргэдийн найдвар, итгэл ийнхүү суларсан нь хөдөө орон нутагт амьдралын байдал хүнд хэцүү хэвээр байгаа, сүүлийн жилүүдэд хотжих хөдөлгөөн ихэссэний зэрэгцээ дэд бүтцийн хөгжил сул, цахилгаан эрчим хүч, усан хангамжийн дутагдалтай байгаа зэрэгтэй холбоотой байж болох юм. Иймээс ХАА-н салбарт дорвитой өөрчлөлт хийх шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйг дан ганц байгалийн үзэгдлийн урсгалаар бус орчин үеийн фермерийн аж ахуйн хэлбэрээр өсгөх хэрэгтэй байна. Газар тариалангийн хувьд гадагш нь импортлодоггүй юм аа гэхэд дотоодын хэрэгцээгээ хангахуйц үйлдвэрлэл явуулж болно гэж үзэж байна. Дээр нь нэмж хэлэхэд ХАА-н бүтээгдэхүүний түүхий эдийн экспортын хэмжээг багасгаж дотооддоо боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг орчин үеийн технологийн үндсэн дээр бий болговол эдийн засгийн өсөлт хөгжилтөнд илүү хувь нэмэр оруулах болно.

Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар нь ДНБ-ий 12.2 хувийг эзэлж байгаа бөгөөд 2001 оноос хойшхи жилийн дундаж өсөлт нь 8.0 хувьтай байна. Санал асуулгад оролцсон иргэдийн 23.5 хувь энэ салбар эдийн засгийн өсөлтийг хангана гэж хариулсан нь 2003 оныхоос 3.9 хувиар илүү байна. 2002, 2003 онуудын уналтыг эс тооцвол энэ салбарын өсөлт тогтмол эерэг хурдацтай байсан байна (Хүснэгт 3.). 2004 онд энэ салбарын өсөлт дээд цэгтээ буюу 34.4 хувьд хүрсэн нь гадаадын хөрөнгө оруулалттай алтны үйлдвэрүүдийн үйл ажиллагаанаас голчлон шалтгаалжээ.

Хүснэгт 3. ДНБ-ий өсөлт, салбаруудаар

	2001	2002	2003	2004	Дундаж	Хувийн жин
ДНБ	1.0%	4.0%	5.6%	10.6%	5.3%	100.0%
Худалдаа, засварлах үйлчилгээ	8.6%	12.8%	7.1%	3.9%	8.1%	26.7%
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	-18.3%	-12.4%	4.9%	19.9%	-1.5%	21.3%
Тээвэр, агуулах, холбоо	12.9%	15.9%	11.1%	9.8%	12.4%	14.3%
Уул уурхай, олборлох үйлдвэр	8.1%	-8.2%	-2.3%	34.4%	8.0%	12.2%
Боловсруулах үйлдвэр	35.3%	19.0%	4.3%	1.8%	15.1%	8.6%
Санхүүгийн үйлчилгээ	21.1%	6.6%	24.5%	21.5%	18.4%	4.0%
Боловсрол	1.1%	4.7%	-4.3%	4.5%	1.5%	4.0%
Төрийн удирдлага, батлан хамгаалах, даатгал	-5.7%	0.8%	-2.5%	-8.7%	-4.0%	3.1%
Барилга	12.4%	14.9%	44.2%	1.3%	18.2%	2.9%
Цахилгаан, дулаан, ус	2.7%	3.2%	1.1%	6.5%	3.4%	2.2%
Эрүүл мэнд, халамж	3.8%	1.2%	-2.1%	-0.2%	0.7%	1.6%
Үл хөдлөх хөрөнгө, түрээс	6.0%	23.4%	21.1%	4.0%	13.6%	1.4%
Зочид буудал, зоогийн газар	-6.9%	3.7%	0.5%	7.3%	1.2%	1.1%
Бусад	9.5%	48.0%	-1.5%	2.6%	14.7%	0.6%

Эх үүсвэр: Монгол улсын статистикийн эмхэтгэл, 2004 (ҮСГ)

Боловсруулах үйлдвэрлэл манай улсын эдийн засагт их үүрэг гүйцэтгэнэ гэж иргэдийн 24.9 хувь үзсэн нь 2003 оныхоос 12.8 хувиар өссөн байна. Энэ жилийн санал асуулгын нэг онцлог бол иргэдийн зүгээс ХАА-н салбар эдийн засгийн өсөлтийг түргэсгэнэ гэсэн хариултын тоо буурч харин боловсруулах үйлдвэрийн салбарынх тэр орчим хувиар өссөн явдал байлаа. Сүүлийн дөрвөн жилийн байдлаар боловсруулах үйлдвэрлэлийг авч үзвэл: 2004 онд ДНБ-ий 8.6 хувийг эзэлж, 2001 оноос 2004 хүртэлх жилийн дундаж өсөлт нь 15.1 хувь буюу салбаруулын дунд гуравт орж байна. Иргэдийн

зүгээс үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийг хүсч байгаа нь боловсруулах үйлдвэрүүдийг бий болгож эдийн засгаа сэргээе гэж бодож байгаа нь тоон үзүүлэлтүүдээс ч харагдаж байна.

Банк санхүүгийн үйл ажиллагаа нь 1997-1998 оны банкны хямралын үед уналтанд орж байсан хэдий ч 1999 онд эргээд сэргэж, 2001-2004 онуудын жилийн дундаж өсөлт нь 18.5 хувь буюу өсөлтөөрөө эдийн засгийн салбаруудыг тэргүүлж байна. Санал асуулгад оролцогчдын 9.8 хувь нь банк санхүүгийн салбарын үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ гэсэн нь 2003 оныхоос 2.4 хувиар буурчээ. Банк санхүүгийн салбар маань хичнээн тогтвортой, үйл ажиллагаа нь төдий чинээ өргөжин тэлэх нь бусад салбаруудын өсөлт хөгжилтөнд их үүрэг гүйцэтгэх болно. Банк санхүүгийн үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувийн жин жилээс жилд нэмэгдэж 2004 оны байдлаар 4.0 хувийг эзэлж байна. Энэ салбарын үйл ажиллагааны талаар дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй дурьдах тул энд товч өгүүлэв.

Аялал жуучлалын салбарыг (шинэ ангиллаар зочид буудал, зоогийн газар) судалгаанд оролцсон иргэдийн 17.5 хувь эдийн засгийн өсөлт хөгжилтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзсэн нь 2003 оныхоос 2.4 хувиар буурчээ. 2001-2004 онуудад тус салбарын жилийн дундаж өсөлт 1.2 хувь, ДНБ-ий 1.1 хувийг эзэлж байгаа нь доогуур үзүүлэлт бөгөөд энэ нь мал амьтны гаралтай халдварт өвчин өнгөрсөн онуудад тархаж байсантай холбоотой. Энэ салбарын ирээдүйн хөгжлийг дэмжиж, таатай орчныг бий болгож чадвал багагүй хэмжээний хөрөнгийн урсгал орж ирнэ гэдэгт асуултанд хариулсан иргэд болон бусад хүмүүс санал нэгтэй байгаа гэдэгт итгэлтэй байна.

Санал асуулгын хариултын хүрээнд хамрагдаагүй зарим гол салбаруудын талаар товчхон дурьдяа. Тухайлбал; тээвэр, агуулах, холбооны салбар нь ДНБ-ий 14.3 хувийг эзэлж байгаа бөгөөд 2001 оноос хойшхи жилийн дундаж өсөлт нь 12.6 хувь, боловсролын салбар нь ДНБ-ий 4.0 хувь, дундаж өсөлт нь 1.5 хувь, барилгын салбар нь ДНБ-ий 2.9 хувь, дундаж өсөлтөөрөө банк санхүүгийн салбарын дараа хоёрт буюу 18.2 хувь байна.

1.4. Өргөн хэрэглээний барааны үнэ таны бодлоор


	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Өсч байна	2365	44.8%	4894	90.8%	46.0%
Буурч байна	276	5.2%	84	1.6%	-3.7%
Тогтворжиж байна	2226	42.2%	316	5.9%	-36.3%
Мэдэхгүй	413	7.8%	94	1.7%	-6.1%
Нийт	5280	100.0%	5388	100.0%	0.0%
Хариулаагүй	1	0.0%	17	0.3%	0.3%
Нийт	5281		5405		

"Хэрэглээний барааны үнэ таны бодлоор" гэсэн асуултанд (1.4.) 90.8 хувь нь өсч, 1.6 хувь нь буурч, 5.9 хувь нь тогтворжиж, 1.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. 2003 онтой харьцуулахад үнэ өсч байна гэсэн хариулт 46.0 хувиар нэмэгдсэн бол буурч байна, тогтворжиж байна гэсэн хариултууд тус

тус 3.7, 36.3 хувиар багасчээ. 1990 оноос эхлэн захиргаадалтын үнийг чөлөөлсний дараа үнийн өсөлт огцом явагдаж (гиперинфляц), 1994 оноос буурч, 1998 оноос эхлэн тогтворжин нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх болсон. 2000 онд үнийн өсөлт бага зэрэг явагдаж хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байсан хэдий ч 2001 оноос 2004 оны 8-р сар хүртэл эргээд нэг оронтой тоонд шилжсэн байна. Харин 2004 оны дунд үеэс эхлэн дэлхийн зах зээлийн шатахууны үнэ өсч эхэлсэн, дотооддоо бензин шатахууны хомсдолд орсонтой холбоотойгоор суурь инфляци, улмаар түүнийг даган хэрэглээний барааны үнэ өсч иргэдийн амьдралд хүндээр туссан байна (Зураг. 3).

2005 оны 8-р сарын байдлаар жилийн инфляцийн түвшин 11.7 хувьтай тэнцүү байгаа бөгөөд цаашид бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна. Үнийн өсөлт бага, эерэг түвшинд, тогтвортой байна гэдэг эдийн засгийн өсөлт хөгжилт болон иргэдийн амьжиргааны түвшин дээшлэхэд их үүрэг гүйцэтгэнэ. Харин манай улсын зах зээл маш бага учир дотоодын үнийн өөрчлөлт гадаад зах зээлийн үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамаарахыг мартаж болохгүй.

Зураг 3. Хэрэглээний барааны үнийн өөрчлөлт



Манай улсын хувьд үнийн өсөлтийг бий болгож байгаа гол шалтгаан нь эдийн засгийн бүтцийн онцлог буюу өөрөөр хэлбэл шатахуун түлшээ 100.0 хувь импортоор нийлүүлдэг, хэрэглээний сагсны 13.0 орчим хувийг эзэлдэг махны үнийг цөөн тооны махны наймаа эрхлэгчид тогтоодогтой холбоотой байна. Дээрх бүтцийн шинж чанартай үнийн өсөлтийг бууруулахад Төв банкны зүгээс бодлогоор нөлөөлөх боломж хязгаарлагдмал байна. Өнөөгийн байдлаар Монголбанк олон улсын жишгийн дагуу суурь хүүгээ өсгөх, ТБҮЦ-аар дамжуулан мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна. Түүний зэрэгцээ ХҮИ-ээс үнийн хэлбэлзэл ихтэй дээрх бүтээгдэхүүнийг хасч цэвэрлэсэн суурь инфляцийг тооцон хэрэглэж байх байр суурьтай байгаа болно. Харин Засгийн газрын зүгээс зхицуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байж болох юм.

3.2. Нийгмийн талаархи асуудлууд

"Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд" гэсэн асуултанд 16.5 хувь нь дээшилсэн гэж хариулсан нь 2003 оныхоос 4.9 хувиар буурсан, 32.0 хувь нь доошилсон гэж үзсэн нь 9.7 хувиар нэмэгдсэн, 49.4 хувь нь хэвэндээ гэсэн нь 4.9 хувиар буурсан дүн гарчээ. Харин 2.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (2.1.). Энэ хариултаас харахад иргэдийн өрхийн амьжиргааны түвшин 2003 оныхоос доошилсны (10.0 орчим хувь) зэрэгцээ ихэнх иргэдийн амьжиргааны түвшин төдийлөн өөрчлөгдөөгүй хэвээр байна. Эдийн засгийн байдал сайжирч өсөлт нь хурдасч байгаа хэдий ч өрхийн амьжиргааны түвшин доошилж байна гэж хариулсан нь нэг талаас эдийн засагт бий болж буй баялаг олон хүнд хүртэхгүй байна гэсэн хардалтыг төрүүлж байна. Үүний зэрэгцээ 32.0 хувь нь амьдрал хэцүү байна гэсэн нь 2004 оны байдлаар Монгол улсын хүн амын 36.3 хувь нь ядуурлын түвшинд байна (Human development report 2005, UNDP) гэсэн баримтанд дөхөж очиж байна.

2.1. Танай өрхийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Дээшилсэн	1130	21.4%	886	16.5%	-4.9%
Доошилсон	1179	22.3%	1717	32.0%	9.7%
Хэвээрээ	2871	54.4%	2652	49.4%	-4.9%
Мэдэхгүй	100	1.9%	110	2.1%	0.2%
Нийт	5280	100.0%	5365	100.0%	0.0%
Хариулаагүй	1	0.0%	40	0.7%	0.7%
Нийт	5281		5405		

Зах зээлийн системд шилжин орсноос хойш манай улсад баян, ядуу, дунд зэрэг нийгмийн янз бүрийн давхаргууд (баян хоосны ялгаа) бий болж тэдний хоорондох ялгаа эрс харагдах болсон билээ. Өмнөх тогтолцооны үед нийгмийн баялгийг тэнцүү хуваан авах зарчимтай байсан бөгөөд шинэ тогтолцоо буюу зах зээлийн системд энэ бүхэн өөрчлөгдсөнийг та бүхэн мэдэж байгаа. Үүнтэй уялдан хувь хүний болон өрхийн амьжиргааны түвшин өөр өөр болж, тэдгээрийн ялгаа эрс өөрчлөгдсөнийг мартаж болохгүй. Харин төр засгаас зохицуулалт хийж бага боловч тэрхүү ялгааг багасгах шаардлагатай байна.

2.2. Хүн амын ядуурал таны бодлоор

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдэж байна	3515	66.6%	4210	78.5%	11.9%
Буурч байна	539	10.2%	340	6.3%	-3.9%
Хэвэндээ байна	949	18.0%	631	11.8%	-6.2%
Мэдэхгүй	276	5.2%	184	3.4%	-1.8%
Нийт	5279	100.0%	5365	100.0%	0.0%
Хариулаагүй	2	0.0%	40	0.7%	0.7%
Нийт	5281		5405		

Санал асуулгад хариулсан иргэдийн 78.5 хувь нь хүн амын ядуурал нэмэгдэж байна гэсэн нь 2003 оныхоос 11.9 хувиар өссөн бол, 6.3 хувь нь буурч байна гэсэн нь 3.9 хувиар, 11.8 хувь нь хэвэндээ байна гэсэн нь 6.2

хувиар тус тус буурчээ. Харин 3.4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (2.2.). Ядуурал нэмэгдэж байна гэсэн хариулт 2003 оныхоос өссөний зэрэгцээ хувийн жин нь өндөр хэвээр байна.

НҮБ-ын Хөглийн хөтөлбөрөөс гаргадаг статистикийн лавлах дээр 2004 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын 36.3 хувь нь ядуурлын түвшинд, 27.0 хувийнх нь орлого буюу хэрэглээ өдрийн нэг америк доллараас доош түвшинд, эдийн засгийн баялгийн 70.0 орчим хувь нь тэгш бус хуваарилагддаг гэж дурьджээ. Ядуурлын түвшингийн динамик өөөрчлөлтийг авч үзвэл, 1985 онд 15.0 орчим байсан бол 1990 онд 10.0 орчим хувь болж буурчээ. Харин 1995 онд 36.3 хувь, 1998 онд 35.6 хувь, 2003 онд 36.1 буюу тогтмол өндөр түвшинд байна (Зураг 5.). Хүн амын гуравны нэг гаруй нь ядуурлын түвшинд байна гэдэг бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад тийм ч өндөр биш боловч ядуурлын түвшинд байна гэж ойлгож болно. Үүний ч нэг үндэслэл бол ОУВС-гаас 2000 оны 9-р сараас эхлэн "Ядуурлыг буруулах, өсөлтийг хангах" (PRGF) хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлж эхлээд байна. Магадгүй уг хөтөлбөр амжилттай хэрэгжихийн зэрэгцээ иргэд маань өөрсдөө хувиараа хөдөлмөр эрхлэж ирээдүйн хуримтлалаа бага боловч бий болгож чадвал нийт хүн амын ядуурал буурах болно. Энэ үйлсэд төр засгийн оролцоо ч (татвар бууруулах, бодит орлогыг бүрдүүлэх суурийг тавьж өгөх, ажлын байрыг шинээр бий болгох, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтыг зөв зохистой хуваарилах, г.м.) их үүрэг гүйцэтгэнэ.


Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор гэсэн асуултанд 81.0 хувь нь нэмэгдэж байна, 5.1 хувь нь буурч байна, 10.0 хувь нь хэвэндээ байна, 3.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (2.3.). 2003 онтой харьцуулахад нэмэгдэж байна гэсэн хариулт 12.0 хувиар өсч, буурч байна, хэвэндээ байна гэсэн нь тус тус 6.0, 4.3 хувиар багасчээ.

2.3. Ажилгүйчүүдийн тоо таны бодлоор


	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдэж байна	3644	69.0%	4357	81.0%	12.0%
Буурч байна	587	11.1%	276	5.1%	-6.0%
Хэвэндээ байна	756	14.3%	538	10.0%	-4.3%
Мэдэхгүй	291	5.5%	206	3.8%	-1.7%
Нийт	5278	100.0%	5377	100.0%	0.0%
Хариулаагүй	3	0.1%	28	0.5%	0.5%
Нийт	5281		5405		

ҮСГ-аас гаргадаг статистикийн мэдээллээс харахад хөдөлмөр эрхлэлтийн албанд албан ёсоор бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 1990 онд 45.7 мянга, 1994 онд 74.9 мянга байсан бол 2002 онд 30.9 мянга болж буурч байсан хэдий ч 2004 оны байдлаар эргээд өсөх хандлага ажиглагдан 35.6 мянга болжээ. Мөн Зураг 4.-өөс харахад ажилгүйдлийн түвшин 1990 онд 5.5 хувь, 1994 онд 8.7 хувь байсан 2002 онд буурч 3.4 хувь болсон байна. Харин 2003 оноос өсч 2004 онд 3.6 хувь болжээ (Зураг4.). 2003 онтой харьцуулахад ажилгүйдэл ихсэж байна гэсэн иргэдийн хариулт өссөнийг статистикийн тоон үзүүлэлтүүд ч бага зэргээр илэрхийлж байна.

**Зураг 4. Ажилгүйчүүдийн тоо, түвшин
(мянган хүн)**



Зураг 5. Ядуурлын хамралтын хүрээ



Монгол улсад төр засгаас ажлын байр нэмэгдүүлэх шат дараалсан тодорхой арга хэмээ авч байгаа, АХБ-аас ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлж байгаа, ажиллах хүчнээ гадаадад бага боловч гаргаж байгаатай уялдан ажилгүйчүүдийн дундаж түвшин сүүлийн жилүүдэд багасаж байна гэж ҮСГ-ын статистикийн мэдээлэл дээр дурьдаж байгаа хэдий ч судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх нь ажилгүйчүүдийн тоо ихсэж байна гэж үзсэн хэвээр байна. Үүнээс харахад статистикийн тоон мэдээлэл иргэдийн хариулт хоёрын хооронд нилээд зөрүү байгаа илэрхий байна.

2.4. Газар хувьчлалыг

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Дэмжиж байна	2947	55.9%	3395	63.6%	7.8%
Дэмжихгүй байна	1508	28.6%	1332	25.0%	-3.6%
Мэдэхгүй	820	15.5%	607	11.4%	-4.2%
Нийт	5275	100.0%	5334	100.0%	0.0%
Хариулаагүй	6	0.1%	71	1.3%	1.2%
Нийт	5281		5405		

Судалгаанд оролцсон иргэдийн 63.6 хувь нь газар хувьчлалыг дэмжиж байна, 25.0 хувь нь дэмжихгүй байна, 11.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (2.4.). Иргэдийн ихэнх нь газар хувьчлалыг дэмжиж, түүнийг ямар чухал гэдгийг нь ойлгож эхэлж байгаа нь 2003 оныхоос дэмжиж байгаа нь 7.8 хувиар өсч, харин дэмжихгүй байгаа нь 3.6 хувиар буурснаар харагдаж байна. Газрыг хувьчлах нь нэг талаас манай улсын иргэдийн хувьд үнэ төлбөргүй тодорхой хэмжээний хувийн өмчтэй болж түүнийгээ захиран зарцуулах эрхтэй болох, нөгөө талаас улсын мэдэлд байсан өмч хувьд очин тодорхой хариуцах эзэнтэй болж хараа хяналтанд орох зэрэг олон сайн талуудтай юм. Харин газрын байршил, үржил шимтэй эсэх болон бусад олон асуудлуудаас шалтгаалан хувьчлал дээр нь маргаантай асуудлууд ихээр гарч байгааг анхаарах хэрэгтэй байна.

3.3. Татварын талаар

Дээр эдийн засгийн ерөнхий асуулгад татварын тухай дурьдсаныг та бүхэн санаж байгаа байх. Судалгаанд хамрагдсан иргэдийн дөрөвний нэг нь

татварын ачааллыг багасгавал эдийн засгийн өсөлтөнд зохих хувь нэмрээ оруулна гэж хариулсан байгаа. Одоо татварын ерөнхий түвшингийн талаар юу бодож байгааг сонирхоё (3.1.). Нийт иргэдийн маань 74.7 хувь нь өндөр гэж хариулсан нь 2003 оныхоос 8.8 нэгжээр өсч, 14.4 хувь нь боломжийн гэсэн нь 8.9 нэгжээр буурчээ. Харин 10.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь 0.1 нэгжээр өссөн байна. Мөн татварын ачаалал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн гэж 67.7 хувь нь үзэж байхад хэвэндээ гэж 18.2 хувь, буурсан гэж 2.2 хувь нь хариулсан байна. 2003 онтой харьцуулахад татварын ачаалал нэмэгдсэн гэж хариулсан нь 5.2 хувиар, хэвэндээ гэсэн нь 3.8 хувиар, буурсан гэсэн нь 2.4 хувиар тус тус багассан бол мэдэхгүй гэж хариулсан нь 11.9 хувиар нэмэгдсэн байна (3.2.).

3.1. Монгол улсад үйлчилж буй татварын ерөнхий түвшин таны бодлоор

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Өндөр	3483	66.0%	4025	74.7%	8.8%
Боломжийн	1229	23.3%	773	14.4%	-8.9%
Мэдэхгүй	569	10.8%	587	10.9%	0.1%
Нийт	5281	100.0%	5385	100.0%	0.0%
Хариулаагүй	0	0.0%	20	0.4%	0.4%
Нийт	5281		5405		


Дээрх хариултуудаас харахад манай улсад үйлчилж буй татварын системийн буруу бодлого болон тогтолцооноос шалтгаалан татварын ерөнхий түвшин маш өндөр, ачаалал нь 2003 онтой харьцуулахад бага зэрэг буурсан (иргэдийн саналаар) мэт харагдаж байгаа хэдий ч хувийн жингээрээ их байж, иргэдийн бодит орлогыг өсгөхгүй, бизнес хийхэд нь саад болж улмаар эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлж байна гэж санал асуулгад оролцсон иргэдийн ихэнх нь дүгнэжээ.

3.2. Татварын ачаалал сүүлийн жилүүдэд

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдсэн	3476	73.3%	3619	67.7%	-5.7%
Хэвэндээ	1042	22.0%	973	18.2%	-3.8%
Буурсан	221	4.7%	119	2.2%	-2.4%
Мэдэхгүй	0	0.0%	638	11.9%	11.9%
Нийт	4739	100.0%	5349	100.0%	0.0%
Хариулаагүй	542	10.3%	56	1.0%	-9.2%
Нийт	5281		5405		

Зураг 6.-гаас харахад зах зээлийн системд шилжсэн эхний жилүүдэд татварын ачаалал (ДНБ-д эзлэх хувийн жингээр) өндөр, хэлбэлзэл нь их байсан бол 1994-1999 онуудад бага зэрэг буурч ойролцоогоор 20 орчим хувьд тогтвортой байсан байна. Харин 2000-2001 онуудад татварын ачаалал огцом нэмэгдэж, 2002-2003 ондуудад тогтворжин 30.0 орчим хувьд байв. 2004 онд эргээд өсч 32.0 хувьд хүрчээ. Эндээс дүгнэж хэлэхэд татварын ерөнхий түвшин өндөр, сүүлийн жилүүдэд ачаалал нь нэмэгдсэн гэсэн иргэдийн дүгнэлттэй бодит байдал тохирч байна.

Зураг 5. Татварын хэмжээ ба ачаалал, сая төгрөг



Энэ хэсэгт бас нэг чухал зүйлийг хэлэхэд татварын түвшин өндөр, ачаалал их байгаа үед татвараас зайлсхийх явдал нийтлэг байна гэж санал асуулгад оролцсон иргэдийн 66.5 хувь үзсэн нь үүний нэг баталгаа болов уу. Харин 9.5 хувь нь бага, 23.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (3.3.). Өнгөрсөн онтой харьцуулахад нийтлэг байна гэж хариулсан нь 1.2 хувиар, бага байна гэсэн нь 3.4 хувиар тус тус буурч, мэдэхгүй гэсэн нь 4.6 хувиар өсчээ. Татвараас зайлсхийх явдал нийтлэг байна гэсэн иргэдийн дүгнэлт бага зэрэг буурсан хэдий ч хувийн жингээрээ өндөр хэвээр байна.

3.3. Татвараас зайлсхийх явдал таны бодлоор

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нийтлэг байна	3576	67.7%	3553	66.5%	-1.2%
Бага байна	682	12.9%	510	9.5%	-3.4%
Мэдэхгүй	1021	19.3%	1278	23.9%	4.6%
Нийт	5279	100.0%	5341	100.0%	0.0%
Хариулаагүй	2	0.0%	64	1.2%	1.1%
Нийт	5281		5405		

3.4. Банк санхүүгийн салбар

2005 оны 8-р сарын 31-ний өдрийн байдлаар Монгол улсад 17 банк, 137 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж, 570 гаруй хадгаламж зээлийн хоршоо бүртгэгдсэн байна.

4.1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоо таны бодлоор

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Олон	1803	34.2%	2151	40.0%	5.8%
Цөөн	420	8.0%	428	8.0%	0.0%
Боломжийн	2657	50.3%	2449	45.5%	-4.8%
Мэдэхгүй	398	7.5%	355	6.6%	-0.9%
Нийт	5278	100.0%	5383	100.0%	0.0%
Хариулаагүй	3	0.1%	22	0.4%	0.4%
Нийт	5281		5405		

Судалгаанд хамрагдсан иргэдийн 45.5 хувь нь үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог боломжийн, 40.0 хувь нь олон байна, 8.0 хувь нь цөөн байна гэж хариулжээ (4.1.). Судалгаанд оролцсон иргэдийн тал орчим хувь нь үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог боломжийн гэж үзсэн нь 2003 оныхоос 4.8 хувиар буурсан, олон байна гэсэн нь 5.8 хувиар ихэссэн байна. Харин мэдэхгүй гэж 6.6 хувь нь хариулжээ.

Ихэнх иргэд маань одоо үйл ажиллагаа явуулж буй банкуудын тоог боломжийн гэж үзэж байна. Энд зарим иргэд маань банк гэсэн ойлголтонд санхүүгийн бусад байгууллагуудыг оруулж ойлгосныг үгүйсгэхгүй. Сүүлийн жилүүдэд олон арван ББСБ болон бусад санхүүгийн байгууллагууд бий болж банкны зарим үйл ажиллагааг бага түвшинд гүйцэтгэж өрсөлдөөнийг бий болгож байна. Иймд Монголбанкны зүгээс банкуудын хэмжээг томосгох, үйл ажиллагааг нь чанаржуулах үүднээс банкуудын дүрмийн санг 2006 онд 8 тэрбум болгохоор шийдвэрлэсэн билээ. Мэдээж тэр үед банкуудын хэмжээ томрон, тоо нь цөөрч, үйл ажиллагаа нь арай өндөр түвшинд явагдаж өрсөлдөх биз. Харин банкны зарим үйл ажиллагааг доод түвшинд банкуудтай зэрэгцэн бусад санхүүгийн байгууллагууд гүйцэтгэнэ. Энд нэг зүйлийг нэмж хэлэхэд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбаруудын тоо тогтмол өсч байхад ББСБ-уудынх их удаашралттай байна.

4.2. Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Найдвартай	2155	40.8%	2417	44.9%	4.1%
Эргэлзээтэй	2237	42.4%	2083	38.7%	-3.7%
Найдваргүй	411	7.8%	347	6.4%	-1.3%
Мэдэхгүй	477	9.0%	535	9.9%	0.9%
Нийт	5280	100.0%	5382	100.0%	0.0%
Хариулаагүй	1	0.0%	23	0.4%	0.4%
Нийт	5281		5405		

Манай улсын банк санхүүгийн салбарын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд сайжирч байна гэж мэргэжилтнүүд болон олон улсын судлаачид дүгнэж байгаа. Харин иргэдийн зүгээс хэрхэн дүгнэж байгааг сонирхоё. Санал асуулгад оролцсон иргэдийн 44.9 хувь нь банк санхүүгийн салбарын үйл ажиллагааг найдвартай гэсэн нь 2003 оныхоос 4.1 хувиар өссөн, 38.7 хувь нь эргэлзээтэй гэсэн нь 3.7 хувиар буурсан, 6.4 хувь нь найдваргүй гэж хариулсан нь 1.3 хувиар багассан байна. Харин 9.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (4.2.). Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ жилээс жилд арилж, найдвар төрүүлж байгаа нь дээрх хариултаас харагдаж байна. Банкны үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ тийм ч бага биш хувийг эзэлж байгаа 1990-ээд оны банкны системийн удаа дараалсан хямралууд нь зарим иргэдийн оюун санаанд хадгалагдсаар байгаа, нөгөө талаас Хадгаламж зээлийн хоршоодын буруу үйл ажиллагаа нь нийт салбарын нэр хүндэд эсрэгээр нөлөөлж байгаатай холбоотой байж болох юм.

Банкинд итгэх итгэл нэмэгдсэн гэж иргэдийн 43.9 хувь нь үзэж байгаа бол 34.9 хувь нь хэвэндээ, 9.4 хувь нь буурсан, 11.7 хувь нь мэдэхгүй


гэж хариулжээ (4.3.). 2003 онтой харьцуулахад нэмэгдсэн гэсэн хариултынх 2.1 хувиар өсч, буурсан, хэвэндээ гэж хариулсных тус тус 1.7, 0.5 хувиар багассан байна. Иргэдийн банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ багасч, итгэх итгэл нь нэмэгдэж байгааг дээрх хариултуудаас харагдаж байна. Үүнийг мөн тоон үзүүлэлтүүдээс ч харж болно.

4.3. Банк санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл


	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Нэмэгдсэн	2206	41.8%	2361	43.9%	2.1%
Буурсан	588	11.1%	505	9.4%	-1.7%
Хэвэндээ	1868	35.4%	1876	34.9%	-0.5%
Мэдэхгүй	615	11.7%	631	11.7%	0.1%
Нийт	5277	100.0%	5373	100.0%	0.0%
Хариулаагүй	4	0.1%	32	0.6%	0.5%
Нийт	5281		5405		

Өнөөгийн байдлаар банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа нь өргөжиж, найдвартай болж байгаа нь иргэдийн итгэл ийнхүү дээшлэхэд нөлөөлсөн байх. Үүний нэг илрэл бол иргэд байгууллагуудын банк дахь хадгаламж, харилцахын хэмжээ өсч байгаа явдал юм.

Зураг 6. Хадгаламж, тэрбум төгрөг



Зураг 7. Харилцах, тэрбум төгрөг



Зураг 6.-гаас харахад төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн хэмжээ 1991 оноос 1997 он хүртэл тогтмол өсч ирсэн ба банкны салбарын хямралын оргил үе болох 1998 онд буурч, 1999-2004 онуудад огцом өсөлттэй явж 625.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. М2-т эзлэх хувийн жингээрээ 2000 оноос эхлэн тогтмол өсч, 2004 оны байдлаар 74.0 орчим хувийг эзэлж байна. Харилцах дансны өөрчлөлт хадгаламжтай адил түвшинд явж 2001 оноос хойш огцом өссөн байна (Зураг 7.). Хадгаламжийн огцом өсөлттэй уялдан харилцахын М2-т эзлэх хувийн жин нь 1998 оноос хойш тогтмол буурч 2004 оны байдлаар 9.2 хувийг эзэлж байна (2001 оныг эс тооцвол). Банкуудын найдвартай үйл ажиллагааг хангах үүднээс Монголбанк банкуудад тавих хяналт шалгалтаа чангатгаж, зээлийн өрийн үлдэгдэлд хязгаарлалт тавих, заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоон мөрдүүлэх зэрэг хэд хэдэн арга хэмжээг авсан ба банкуудын касс дахь бэлэн мөнгөний хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж, ингэснээр

харилцагч нарын төлбөр, тооцоог түргэн шуурхай гүйцэтгэдэг болсон нь хүмүүсийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

Банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа олон нийтэд сайн сурталчилж эхэлж байгаа нь дараахь хариултаас харагдаж байна. Чадаж байна гэсэн хариулт 2003 оныхоос 2.8 нэгжээр нэмэгдэж 66.2 хувьд, чадахгүй байна 4.4 нэгжээр буурч 19.8 хувьд, мэдэхгүй 1.6 нэгжээр өсч 14.0 хувьд хүрчээ (4.4.).

4.4. Банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчилж

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Чаждаж байна	3343	63.4%	3552	66.2%	2.8%
Чадахгүй байна	1279	24.3%	1065	19.8%	-4.4%
Мэдэхгүй	651	12.3%	750	14.0%	1.6%
Нийт	5273	100.0%	5367	100.0%	0.0%
Хариулаагүй	8	0.2%	38	0.7%	0.6%
Нийт	5281		5405		

Банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ багассан, итгэх итгэл нь нэмэгдсэн энэ үед үйлчилгээ нь хэр зэрэг түргэн шуурхай явагдаж байгааг сонирхоё. Асуултанд хариулсан иргэдийн 58.5 хувь нь хувь хүнд хүрч түргэн шуурхай байна гэж хариулсан нь 2003 оныхоос 1.6 хувиар өсчээ. Харин 29.1 хувь нь хүнд сурталтай чирэгдэлтэй байна гэсэн нь 1.6 хувиар буурч, 12.4 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (4.5.).

4.5. Банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээ

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Хувь хүнд хүрч, хэвийн байна	3000	56.9%	3121	58.5%	1.6%
Хүнд сурталтай, чирэгдэлтэй	1619	30.7%	1555	29.1%	-1.6%
Мэдэхгүй	654	12.4%	660	12.4%	0.0%
Нийт	5273	100.0%	5336	100.0%	0.0%
Хариулаагүй	8	0.2%	69	1.3%	1.1%
Нийт	5281		5405		

Танд мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандвал боломжтой вэ гэсэн сонирхолтой асуултанд 45.2 хувь нь банк, 21.2 хувь нь хувь хүн, 15.6 хувь нь ломбард, 6.8 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, 5.8 хувь нь ББСБ, 5.4 хувь нь бусад эх үүсвэр гэж хариулжээ (4.6.). 2003 оныхоос банк, ББСБ гэж хариулсан нь тус тус 6.6, 1.1 хувиар буурсан нь энэ онд шинээр хадгаламж зээлийн хоршоог нэмсэнтэй холбоотой болно. Хүнд мөнгөний хэрэгцээ гарвал хамгийн түрүүнд банкинд, дараа нь найз нөхөд, дотны хүмүүс болон ломбарданд ханддаг байна. Банкуудын үйл ажиллагаа сайжирч, үйлчилгээнийх нь төрөл ихэссэн, зөвхөн цөөн тооны найдвартай харилцагчдад их хэмжээний зээл олгохын зэрэгцээ цалин тэтгэврийн болон бусад төрлийн бичил зээлийг (үйлчилгээ) өргөн хүрээтэй олгож байгаа нь иргэдийн тэмүүллийг өөрсдийн зүг татаж байгаагийн илрэл юм.

4.6. Танд мөнгөний хэрэгцээ гарвал хаашаа хандах вэ?

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Банк	2734	51.8%	3217	45.2%	-6.6%
ББСБ	367	7.0%	414	5.8%	-1.1%
Хадгаламж зээлийн хоршоо			486	6.8%	6.8%
Ломбард	751	14.2%	1109	15.6%	1.4%
Хувь хүн	1138	21.6%	1506	21.2%	-0.4%
Бусад	290	5.5%	388	5.4%	0.0%
Нийт	5280	100.0%	7120	100.0%	0.0%
Хариулаагүй	1	0.0%	-1715	-31.7%	-31.7%
Нийт	5281		5405		

Бусад санхүүгийн байгууллагуудын хувьд тоо хэмжээ нь хурдтайгаар өсч байгаа хэдий ч санал асуулгын хариултанд эзлэх хувийн жин нь их бага байна. Энэ нь үйл ажиллагаа нь төлөвшиж тогтворжоогүй, үйлчилгээ нь олон нийтийг зөв хамруулж чадахгүй байгаатай холбоотой.

Өнөөгийн байдлаар Монгол улсад нийт 137 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа явуулж, хот, хөдөө орон нутгийн иргэдийг өөрсдийн харилцагчдаа болгон тэдэнд тодорхой хэмжээний үйлчилгээ үзүүлж байна. Судалгаанд оролцсон иргэд маань ББСБ-ын талаар хэр мэдлэгтэй байгааг сонирхоё. Асуултанд хариулсан нийт иргэдийн 37.9 хувь нь ББСБ-аар үйлчлүүлдэг, 58.2 хувь нь үйлчлүүлдэггүй, 3.9 хувь мэдэхгүй хариулжээ (4.7.). 2003 онтой харьцуулахад үйлчлүүлдэг болон үйлчлүүлдэггүй гэсэн хариултуудын тоо тус тус 0.4, 1.3 нэгжээр өсч, мэдэхгүй гэсэн хариултын тоо 1.8 хувиар буурсан байна.

4.7. Та банк бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлдэг үү?

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	1973	37.4%	2027	37.9%	0.4%
Үгүй	3001	56.9%	3117	58.2%	1.3%
Мэдэхгүй	301	5.7%	211	3.9%	-1.8%
Нийт	5275	100.0%	5355	100.0%	0.0%
Хариулаагүй	6	0.1%	50	0.9%	0.8%
Нийт	5281		5405		

Үүнээс дүгнэхэд тоо нь олширч байгаа хэдий ч ББСБ-ууд маань цөөн тооны харилцагчдын хүрээнд үйлчилгээ явуулж байна. Мөн энд нэмж хэлэхэд сурталчилгаа сайн явуулж иргэдийг олноор татах шаардлагатай байна. ББСБ нь манай улсын хувьд шинээр бий болж буй санхүүгийн байгууллагын нэг хэлбэр юм. Удирдах байгууллагуудын зүгээс түүний хөгжлийг дэмжиж байгаа хэдий ч ажлын дадлага туршлага, боловсон хүчний мэдлэг, ур чадвар дутмаг байгааг хэлэхэд илүүдэхгүй биз. Нөгөө талаас банк, ББСБ, бусад санхүүгийн байгууллагууд зах зээлийн зарчмын дагуу өрсөлдөөнийг бий болгож чадвал хүүний түвшин буурч хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэн үйлчилгээ нь хувь хүн болгонд хүрнэ гэдгийг хэлмээр байна.

Хадгаламж зээлийн хоршооны талаар 2002 оны санал асуулгаар ерөнхий асуулт тавьж байснаас 2003 онд дурьдалгүй өнгөрсөн болно. Харин 2005 онд энэ байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан нилээд дэлгэрэнгүй авч үзлээ. Санал асуулгад оролцсон иргэдийн 46.3 хувь нь хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголтой, 35.5 хувь нь ойлголтгүй, 18.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. 2005 оны байдлаар улсын хэмжээгээр 570 гаруй хадгаламж зээлийн хоршоо бүртгэлтэй байгаагаас хууль журмын дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа нь тун цөөхөн. Зөвшөөрөл аваад үйл ажиллагаа явуулаагүй хоршоод ч нилээд бий.

4.8. Та хадгаламж зээлийн хоршооны талаар ойлголтой юу

	2003		2005		Өөрчлөлт
			Хүний тоо	Хувь	
Тийм			2477	46.3%	
Үгүй			1900	35.5%	
Мэдэхгүй			970	18.1%	
Нийт			5347	100.0%	
Хариулаагүй			58	1.1%	
Нийт			5405		

Судалгаанд оролцсон иргэдийн 12.6 хувь нь хадгаламж зээлийн хоршооны гишүүн, 82.4 хувь нь гишүүн бус байлаа. Харин 5.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (4.9.). Санал асуулгад оролцсон иргэдийн тал орчим хувь нь ХЗХ-ны талаар ойлголттой, 10 гаруй хувь нь түүний гишүүн байв.

4.9. Та хадгаламж зээлийн хоршооны гишүүн мөн үү

	2003		2005		Өөрчлөлт
			Хүний тоо	Хувь	
Тийм			672	12.6%	
Үгүй			4410	82.4%	
Мэдэхгүй			272	5.1%	
Нийт			5354	100.0%	
Хариулаагүй			51	0.9%	
Нийт			5405		

Иргэдийн зүгээс хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хуулийн дагуу зөв явагдаж байна гэж 32.2 хувь нь үзсэн байхад хууль бус буюу буруу гэж 11.3 хувь нь дүгнэжээ. Харин ихэнх нь буюу 56.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (4.10.). Дээрхээс харахад судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү хувь нь ойлголт байхгүй, 80.0 гаруй хувь нь гишүүн бус байсан тул тус хоршооны үйл ажиллагааны талаар ихэнх нь мэдлэг муутай байв. Хэдийгээр иргэдийн төлөөллийн 32.2 хувь нь хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааг сайшааж байгаа ч бодит байдал дээр ямар байгааг дараахь хэдэн өгүүлбэрээр тайлбарлая. Тооны хувьд газар авсан хэдий ч үйл ажиллагаагаа хуулийн дагуу тогтвортой явуулж байгаа нь тун цөөхөн. Хууль бусаар реклам, сурталчилгаа тогтмол явуулахын зэрэгцээ иргэдэд хадгаламжийн байж боломгүй өндөр хүү амлан, хөрөнгийг нь татан төвлөрүүлчихээд хугацаанд буцааж төлөхгүй байх улмаар бүрмөсөн төлөхөөс зайлсхийх явдал нийтлэг болсон. Иймээс энэ байгууллагын хууль зүйн хүрээг чангатгах, түүнд тогтмол хяналт тавих

бүтцийг бий болгох, цаашид иргэддээ мэдээллийн хэрэгслээр дамжуулан анхааруулга, сэрэмжлүүлэг өгч байх шаардлагатай байна.

4.10. Та хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг хэрхэн дүгнэж байна

	2003		2005		Өөрчлөлт
			Хүний тоо	Хувь	
Зөв буюу хуулийн дагуу			1719	32.2%	
Буруу буюу хууль бус			605	11.3%	
Мэдэхгүй			3017	56.5%	
Нийт			5341	100.0%	
Хариулаагүй			64	1.2%	
Нийт			5405		

Өнөөдөр манай улсад гадаадын болон гадаадын хөрөнгө оруулалттай хэд хэдэн банк, ББСБ-ууд үйл ажиллагаа явуулж байна. Гадаадын банк санхүүгийн байгууллагыг Монголд оруулж ирэх нь манай улсад орж ирэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн улмаар үндэсний үйлдвэрлэлийг сэргээж дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ. Түүний зэрэгцээ манай улсын банк санхүүгийн салбарт зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож банк санхүүгийн байгууллагуудыг чанаржуулахад тус дөхөм болно.

4.11. Гадаадын банк, санхүүгийн байгууллагыг оруулж ирэх нь

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Ач холбогдолтой	2758	52.3%	2484	46.5%	-5.8%
Ач холбогдолгүй	969	18.4%	1065	20.0%	1.6%
Мэдэхгүй	1546	29.3%	1789	33.5%	4.2%
Нийт	5273	100.0%	5338	100.0%	0.0%
Хариулаагүй	8	0.2%	67	1.2%	1.1%
Нийт	5281		5405		

Одоо манай иргэдийн зүгээс гадаадын банк болон санхүүгийн байгууллагуудыг Монголд оруулж ирэх нь ямар ач холбогдолтой вэ гэдгийг сонирхоё. 46.5 хувь нь ач холбогдолтой гэж хариулсан нь 2003 оныхоос 5.8 хувиар буурсан, 20.0 хувь нь ач холбогдолгүй гэсэн нь 1.6 хувиар өссөн, 33.5 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь 4.2 хувиар нэмэгдсэн байна (5.9.). Иргэдийн төлөөллийн тал орчим хувь нь зөв буюу ашигтай гэж үзэж байгаа нь дээрх санаатай нэг байна гэсэн үг. Нэг зүйлийг нэмж хэлэхэд гадаадын банк санхүүгийн байгууллагуудыг оруулж ирэх нь манай улсын эдийн засгийн өсөлт хөгжилтөнд ашигтай харин улсынхаа эдийн засгийн багтаамж, зах зээлийн байдал, банк санхүүгийн салбарын хөгжил түүнд учруулж болзошгүй хохирлуудыг сайн тооцоолж тодорхой хэмжээгээр оруулах нь зөв болов уу.

Өнгөрсөн онуудын судалгаагаар бэлэн бус тооцоо болон түүний хэрэгслүүдийн (картууд) талаар нилээд дэлгэрэнгүй санал асуулга явуулж нэгтгэн дүгнэсэн болно. Иргэдийн ихэнх хувь нь ойлголт байхгүй түүний давуу талыг мэдэхгүй байсан. Харин энэ жилийн хувьд маш товчхон буюу нэг л асуултыг хамрууллаа. Бэлэн бус тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг үү гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан иргэдийн 21.4 хувь нь тийм, 70.52 хувь нь үгүй, 8.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (4.12.).

Эндээс харахад иргэдийн ихэнх нь урьдын адил бэлэн бус тооцоо болон түүний хэрэгслүүдийн талаар ойлголт муутай, картыг хэрэглэдэггүй буюу хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэнд хүрч байна. 2003 онтой харьцуулахад карт хэрэглэдэг иргэдийн тоо 8.8 нэгжээр өссөн байна.

4.12. Та бэлэн бус тооцооны хэлбэр болох картыг хэрэглэдэг үү?

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	665	12.6%	1143	21.4%	8.8%
Үгүй	4181	79.2%	3760	70.5%	-8.8%
Мэдэхгүй	430	8.2%	431	8.1%	-0.1%
Нийт	5276	100.0%	5334	100.0%	0.0%
Хариулаагүй	5	0.1%	71	1.3%	1.2%
Нийт	5281		5405		

3.5. Хадгаламж, хуримтлал

"Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ?" гэсэн асуултанд давхардсан тоогоор 27.4 хувь нь банкинд хадгалуулдаг, 7.7 хувь нь бусад зээлдүүлдэг, 26.6 хувь нь худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, 1.2 хувь нь үнэт цаасанд байршуулдаг, 1.4 хувь нь хувьцаа худалдаж авдаг, 31.7 хувь нь бусад гэсэн хариултыг өгчээ. Зарим нэг хариултыг 2003 оныхтой харьцуулахад банкинд хадгалуулдаг гэснийх 5.6 хувиар өссөн, бусад зээлдүүлдэг, худалдаа наймаа хийж эргэлдүүлдэг, бусад хэлбэрээр гэж хариулсных тус тус 1.7, 4.0, 3.4 хувиар буурсан байна. Энэ хэсэгт дүгнэж хэлэхэд иргэдэд хэрвээ хуримтлуулсан мөнгө байдаг бол ихэнх тохиолдолд худалдаа наймаа хийх буюу банк санхүүгийн байгууллагад хадгалуулдаг байна. Харин хувийн жингээрээ хамгийн их (31.7 хувь) буюу бусад гэсэн хариултанд хуримтлуулах мөнгөгүй эсвэл мөнгөө бэлнээр өөр дээрээ байлгадаг иргэд хамрагдсан болов уу гэсэн таамаглалыг төрүүлж байна

5.1. Та хуримтлуулсан мөнгөөрөө юу хийдэг вэ

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Банкинд хадгалуулдаг	1287	21.9%	1615	27.4%	5.6%
Зээлдүүлдэг	556	9.4%	454	7.7%	-1.7%
Худалдаа наймаа хийдэг	1806	30.7%	1568	26.6%	-4.0%
Үнэт цаасанд байршуулдаг	85	1.4%	71	1.2%	-0.2%
Хувьцаа худалдаж авдаг	89	1.5%	80	1.4%	-0.2%
Бусад	2062	35.0%	1864	31.7%	-3.4%
Нийт	5885	100.0%	5885	100.0%	0.0%
Хариулаагүй	-604	-11.4%	-480	-8.9%	2.6%
Нийт	5281		5405		

"Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулдаг вэ?" гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан иргэдийн 63.0 хувь нь бэлэн мөнгөний хэлбэрээр, 15.1 хувь нь бэлэн бус мөнгөний хэлбэрээр, 4.3 хувь нь үнэт цаасанд, 3.5 хувь нь хувьцаанд, 14.0 хувь нь бусад хэлбэрээр байршуулдаг гэж хариулжээ (5.2.). Банк санхүүгийн байгууллагуудын тоо, үйлчилгээний төрөл олширч (хүн ам төвлөрсөн газруудад), бэлэн бус төлбөр тооцооны систем хөгжиж буй энэ үед иргэдийн 63.0 хувь нь мөнгөө бэлнээр хадгалж байгаа нь нэгт,

бэлэн бус төлбөр тооцооны систем буюу шаардлагатай үед бэлэн мөнгө авах нөхцөл нийт нутаг дэвсгэрийг хамарч чадаагүй, ялангуяа хөдөө орон нутагт огт хөгжөөгүй; хоёрт, санхүүгийн зах зээлийн хөгжил сул дорой учир үнэт цаас, хувьцаа болон бусад хэрэгслүүдэд мөнгөө байршуулах боломжоор хязгаарлагдмал; гуравт, ямар нэгэн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх мөнгөгүй зөвхөн амьжиргааныхаа хэдэн төгрөгтэй явдаг иргэд олон байгаатай холбоотой гэж үзэж байна.

5.2. Та мөнгөө ямар хэлбэрээр байршуулахыг илүүд үздэг вэ

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Бэлэн мөнгөөр	3683	69.7%	3550	63.0%	-6.7%
Бэлэн бус мөнгөний хэлбэрээр	759	14.4%	853	15.1%	0.8%
Үнэт цаасаар	137	2.6%	245	4.3%	1.8%
Хувьцаагаар	88	1.7%	198	3.5%	1.8%
Бусад хэлбэрээр	614	11.6%	788	14.0%	2.4%
Нийт	5281	100.0%	5634	100.0%	0.0%
Хариулаагүй	0	0.0%	-229	-4.2%	-4.2%
Нийт	5281		5405		


Дээрх асуултуудтай уялдсан бас нэг сонирхолтой асуултанд юу гэж хариулсныг сонирхоё. Танд хэмнэх мөнгө гараад түүнийгээ банкинд юм уу эсвэл өөр ямар нэгэн газар байршуулах бол ямар валютыг илүүд үзэж байна вэ гэсэн асуултанд 88.6 хувь нь төгрөгөөр, 6.3 хувь нь америк доллараар, 5.0 хувь нь бусад валютаар гэж хариулжээ (5.3.). 2003 онтой харьцуулахад төгрөгөөр гэсэн нь 0.7 хувиар өсч, америк долларынх 1.3 хувиар буурсан байна. Иргэд маань ийнхүү үндэснийхээ валютаар хуримтлалаа байршуулахыг илүүд үзэж байгаа нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшны уналт харьцангуй багассан, төгрөгийн хадгаламжийн хүү өндөр байгаатай холбоотой болов уу. Мөн банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд илт сэргэсэн, Монгол улсын хүн ам төвлөрсөн нутаг дэвсгэрт төгрөгийн бэлэн бус төлбөр тооцооны шинэ хэрэгслүүд эрчимтэй хөгжиж байгааг дурьдахад илүүдэхгүй биз. Түүний зэрэгцээ хөдөө орон нутагт зөвхөн төгрөгөөр голчлон үйлчилгээ явагдаж байна.

5.3. Та мөнгөө ямар валютаар хадгалдаг вэ

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Төгрөгөөр	4639	87.9%	4442	88.6%	0.7%
Америк доллараар	406	7.7%	318	6.3%	-1.3%
Бусад	232	4.4%	252	5.0%	0.6%
Нийт	5277	100.0%	5012	100.0%	0.0%
Хариулаагүй	4	0.1%	393	7.8%	7.8%
Нийт	5281		5405		

Зураг 8.-аас харахад 1991-1996 онуудад төгрөгийн хадгаламжийн хэмжээ давамгайлж байсан (1993 оныг оруулалгүйгээр) бол 1997-2001 он хүртэл валютын хадгаламж зонхилсон байна (1998 оныг оруулалгүйгээр). 2002 онд төгрөгийн хадгаламжийн хэмжээ эргээд валютынхаас илүү гарсан хэдий ч 2003, 2004 онуудад валютынх давамгайлсан байна.

Зураг 8. Төгрөгийн болон валютын хадгаламж, Зураг 9. Хадгаламжийн хүү ба инфляци, тэрбум төгрөг



Өрхөд нь хэмнэх мөнгө гардаг болон гарах тохиолдолд иргэдийн 27.4 хувь нь банкинд мөнгөө хадгалуулдаг гэж хариулсныг санаж байгаа байх. Одоо харин тэдгээр иргэдээс болон бусад санал асуулгад оролцсон хүмүүсээс өнөөгийн хадгаламжийн хүү ямар түвшинд байгааг асууя. Асуултанд хариулсан иргэдийн 27.6 хувь нь одоогийн хадгаламжийн хүүний түвшин боломжийн байна, 57.6 хувь нь бага байна, 14.8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (5.4.). 2003 онтой харьцуулахад бага байна гэсэн хариултынх 2.3 хувиар нэмэгдсэн байхад боломжийн байна гэснийх 3.4 хувиар буурсан байна. Иргэд маань аль болох өндөр хүүтэйгээр хадгаламжаа байршуулахыг хүсэх нь мэдээж. Харин эдийн засгийн болон зах зээлийн байдлыг сайн судалж аль болох найдвартай, ашигтай зүйлд хөрөнгөө байршуулах нь зөв юм. Магадгүй энэ тал дээр мэдээлэл хомс, үйл ажиллагаа хязгаарлагдмал байгааг удирдах газрууд анхааралдаа авах хэрэгтэй байна. Сүүлийн жил гаруй хугацааны үнийн өсөлтийг эс тооцвол инфляцийн түвшин тогтмол буурч нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх болсон нь хадгаламжийн хүүний түвшинг багасахад нөлөөлсөн байж болох талтай. Хэдий тийм ч 1997 оны 9-р сараас эхлэн бодит хүүний түвшин эерэг түвшинд байгааг анхааралдаа авна уу (Зураг 9.).

5.4. Хадгаламжийн хүү таны бодлоор

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Бага байна	2904	55.4%	3031	57.6%	2.3%
Боломжийн байна	1628	31.0%	1451	27.6%	-3.4%
Мэдэхгүй	713	13.6%	777	14.8%	1.2%
Нийт	5245	100.0%	5259	100.0%	0.0%
Хариулаагүй	36	0.7%	146	2.8%	2.1%
Нийт	5281		5405		

3.6. Зээл

Хүн бүрт зээлийн эрэлт хэрэгцээ ямар нэгэн хэмжээгээр байдаг байх. Гагцхүү тэр эрэлт хэрэгцээний эх үүсвэрийг (нийлүүлэлт) яаж олох, мөн тухайн эх үүсвэрийн өртөг (хүү) ямар түвшинд байгааг сайн тооцоолох хэрэгтэй болов уу. Өнөөгийн байдлаар инфляцийн түвшин багасч тогтворжин, түүнийг даган хадгаламжийн хүү буурч байгаа хэдий ч зээлийн хүү дорвитой буурахгүй байгаа нь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг хаан боогдуулах улмаар эдийн засгийн өсөлтөнд сөрөг үзүүлж болзошгүй юм.

6.1. Танд зээлийн хэрэгцээ байдаг уу

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	4249	80.5%	4464	83.5%	3.1%
Үгүй	839	15.9%	721	13.5%	-2.4%
Мэдэхгүй	192	3.6%	159	3.0%	-0.7%
Нийт	5280	100.0%	5344	100.0%	0.0%
Хариулаагүй	1	0.02%	61	1.13%	1.1%
Нийт	5281		5405		

Зээлийн хэрэгцээ танд байдаг уу гэсэн асуултанд 83.5 хувь нь тийм, 13.5 хувь нь үгүй гэж хариулсан байна (6.1.). Харин 3.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Зээлийн хэрэгцээ байдаг гэж хариулсан хүмүүсийн хувь 2003 оныхоос 3.1 хувиар өссөн бол байдаггүй гэснийх 2.4 хувиар буурсан байна. Эндээс харахад зээлийн эрэлт нэмэгдэж, урьдын адил өндөр хэвээр байна.

6.2. Танд банк санхүүгийн байгууллагаас олгож буй зээл хүртээмжтэй байдаг уу

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Тийм	1753	33.2%	2229	42.1%	8.9%
Үгүй	2461	46.6%	2035	38.5%	-8.2%
Мэдэхгүй	1063	20.1%	1026	19.4%	-0.7%
Нийт	5277	100.0%	5290	100.0%	0.0%
Хариулаагүй	4	0.1%	115	2.1%	2.1%
Нийт	5281		5405		


Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнхид (80.5 хувь) зээлийн хэрэгцээ байдаг бөгөөд харин хүртээмж нь зөвхөн 42.1 хувьд нь л ногддог байна. 38.5 хувьд нь зээлийн хүртээмж байдаггүй бөгөөд 19.4 хувь нь зээлийн талаар ойлголт муутай гэж хариулжээ (6.2.). 2003 онтой харьцуулахад зээлийн хүртээмж 8.9 нэгжээр өсчээ.

Зээлийн эрэлт өндөр, хүртээмж буюу нийлүүлэлт бага байгаа энэ үед банк санхүүгийн байгууллагуудаас зээл авахад хүндрэлгүй гэж судалгаанд оролцсон иргэдийн 38.3 хувь, хүндрэлтэй гэж 46.5 хувь, мэдэхгүй гэж 15.1 хувь нь үзжээ. 2003 онтой харьцуулахад хүндрэлгүй гэсэн хариултын хувь 5.9 хувиар нэмэгдэж, хүндрэлтэй болон мэдэхгүй гэсэн хариултынх тус тус 5.3, 0.6 хувиар буурчээ (6.3). Эндээс харахад зээл авдаг (хүртээмжэй) иргэдийн хувьд хүндрэл байдаггүй бөгөөд авч үзээгүй, авдаггүй эсвэл ойлголт байхгүй (зээлийн эрэлт хэдий байгаа ч) иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг байна.


6.3. Таны бодлоор банк санхүүгийн байгууллагаас зээл авахад

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Хүндрэлгүй	1710	32.4%	2044	38.3%	5.9%
Хүндрэлтэй	2731	51.8%	2479	46.5%	-5.3%
Мэдэхгүй	830	15.7%	807	15.1%	-0.6%
Нийт	5271	100.0%	5330	100.0%	0.0%
Хариулаагүй	10	0.2%	75	1.4%	1.2%
Нийт	5281		5405		

Зураг 10. Зээл, тэрбум төгрөг



Зураг 11. Зээлийн хүү ба инфляци, жилээр



Инфляцын түвшин (сүүлийн жил гаруй хугацааг эс тооцвол) буурч түүнийг даган хадгаламжийн хүү багасаж байхад зээлийн хүү дорвитой буурч өгөхгүй байна гэж нэгэнтээ ярьж байсныг санаж байгаа байх (Зураг 11). Харин одоо санал асуулгад оролцсон иргэд маань зээлийн хүүний талаар юу гэж бодож байгааг сонирхоё. 69.6 хувь нь зээлийн хүүг өндөр байна гэж хариулсан нь өнгөрсөн оныхоос 9.4 хувиар нэмэгдсэн, 20.4 хувь нь боломжийн гэсэн нь 8.6 хувиар буурчээ. Харин 10.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна (6.4.). Энд нэг зүйлийг онцлон хэлэхэд банкууд зээл олгохдоо зээлийн эх үүсвэр, зориулалт, хугацаа болон харилцагчдын байдлыг харгалзан хүүг нэгээс дөрөв хүртэлх хувиар тогтоож байна. Судалгаанд оролцсон иргэдийн хэд нь банкнаас зээл авдаг, авдаггүйг сайн мэдэхгүй. Магадгүй зарим нь өндөр хүүгээр, зарим нь бага хүүгээр авдаг байх. Хэдий тийм ч 70 орчим хувь нь одоогийн зээлийн хүүг өндөр гэж үзэж байгаа нь зээлийн хүүг салбарын хэмжээгээр буулгах дохио болж буйг харуулж байна.

Зээлийн хүүг салбарын хэмжээгээр бууруулах тал дээр Монголбанкны удирдлагын зүгээс нилээд арга хэмжээ авч хэрэгжүүлээд байна. Үүнд: банкуудын удирдлагуудтай хэд хэдэн удаа уулзалт зохион байгуулж зээлийг хүүг яаж багасгах тал дээр санаа сэтгэгдлээ солилцсон, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран төслийн хүрээнд ажлын байр шинээр бий болгох, ХАА-г хөгжүүлэх болон орон сууцны зориулалттай урт болон дунд хугацааны бага хүүтэй зээлийг банкуудаар дамжуулан олгох ажлыг зохион байгуулж байгаа, санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнийг (ялангуяа зээлийн талаар) бий болгохын тулд ББСБ-ын үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлахгүй олгож байгаа зэрэг болно.

6.4. Таны бодлоор зээлийн хүү

	2003		2005		Өөрчлөлт
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь	
Өндөр	3175	60.2%	3689	69.6%	9.4%
Боломжийн	1529	29.0%	1080	20.4%	-8.6%
Мэдэхгүй	568	10.8%	533	10.1%	-0.7%
Нийт	5272	100.0%	5302	100.0%	0.0%
Хариулаагүй	9	0.2%	103	1.9%	1.7%
Нийт	5281		5405		

3.7. Бичил санхүүгийн талаар

Манай улсад сүүлийн жилүүдэд бичил санхүүгийн үйл ажиллагаа улам өргөжин тэлж байна. Бичил санхүүгийн үйл ажиллагааг зөвхөн банкууд биш банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод болон бусад байгууллагууд эрхэлж байна. Бичил санхүүгийн үндэсний чуулган 2004 оны 11-р сард болсны зэрэгцээ түүний дэд салбарын судалгааг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хийсэн тул энд дэлгэрэнгүй тайлбар хийхийг зорисонгүй зөвхөн иргэдийн зүгээс ямар санаа бодолтой байгааг тусган харууллаа. Бичил зээлийн талаар болон манай улсад хэрхэн хөгжиж буйг “Бичил зээл ба бизнес үндэсний чуулган”, 1994 он, “Монгол дахь бичил санхүүгийн дэд салбарын судалгаа” 2004 он зэрэг товхимлуудтай танилцаж сайн ойлголт авч болно.

Та бичил санхүүгийн талаар ойлголттой юу гэсэн асуултанд судалгаанд оролцсон иргэдийн 67.3 хувь нь тийм, 17.8 хувь үгүй, 14.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ (7.1.). Эндээс харахад бичил санхүүгийн үйл ажиллагаа манай оронд нилээд дэлгэрсэн иргэдийн төлөөллийн дийлэнх хувь нь ойлголттой байна.

7.1. Та бичил санхүүгийн талаар ойлголттой юу

			2005	
			Хүний тоо	Хувь
Тийм			3595	67.3%
Үгүй			952	17.8%
Мэдэхгүй			794	14.9%
Нийт			5341	100.0%
Хариулаагүй			64	1.2%
Нийт			5405	

Бичил санхүүгийн талаар иргэдийн дийлэнх нь ойлголттой байгаа бол тэдний оршин суугаа газар энэхүү шинэ хэлбэрийн санхүүжилт нь хэр хөгжиж байгааг сонирхоё. Асуултанд хариулсан иргэдийн 24.0 хувь нь сайн хөгжсөн, 46.2 хувь нь дунд зэрэг хөгжсөн, 12.8 хувь нь огт хөгжөөгүй, 20.6 хувь нь мэдэхгүй гэжээ (7.2.). Энэ хариултаас харахад судалгаанд оролцсон иргэдийн 70.2 хувь нь өөрсдийн оршин сууж байгаа газарт бичил санхүүгийн үйл ажиллагаа явагдаж байгааг дурьдсан нь дээрх асуултын (7.1.) хариултыг давхар нотлон харуулж байна.

7.2. Таны оршин сууж байгаа газарт бичил санхүү хэр зэрэг хөгжсөн бэ

			2005	
			Хүний тоо	Хувь
Сайн			1289	24.0%
Дунд зэрэг			2295	42.6%
Огт хөгжөөгүй			688	12.8%
Мэдэхгүй			1110	20.6%
Нийт			5382	100.0%
Хариулаагүй			23	0.4%
Нийт			5405	

Иргэдийн 70.0 орчим хувь нь бичил санхүүгийн талаар ойлголцогтойгийн зэрэгцээ тэдний оршин суугаа нийт газрын мөн тийм орчим хувьд үйл ажиллагаа нь явагдаж байгаа нөхцөлд яг хувь хүн өөрт нь бичил зээл авах боломж байгаа эсэхийг тодруулбал, 59.1 хувьд нь боломж бий, 23.0 хувьд нь байхгүй гэж хариулсан байна (7.3.). Харин 17.8 хувь нь мэдэхгүй гэжээ. Үүнээс үзэхэд боломж нь хөгжлөөсөө 10 орчим хувиар доогуур байна. Энэ тийм ч их муу зүйл бас биш юм.

7.3. Танд бичил зээл авах боломж бий юу

			2005	
			Хүний тоо	Хувь
Тийм			3124	59.1%
Үгүй			1216	23.0%
Мэдэхгүй			942	17.8%
Нийт			5282	100.0%
Хариулаагүй			123	2.3%
Нийт			5405	

Судалгаанд хамрагдсан иргэдийн 60.0 орчим хувь нь бичил зээл авах боломжтой гэж дээр хариулсныг санаж байгаа байх. Харин одоо түүгээр юу хийдэг буюу ямар бизнес эрхэлдэгийг нь тодруулъяа.

7.4. Хэрвээ бичил зээл авч ашигладаг бол ямар үйл ажиллагаа (бизнес) эрхэлдэг вэ

			2005	
			Хүний тоо	Хувь
Газар тариалан			343	6.1%
Хүнсний ногоо			380	6.8%
Мал аж ахуй			471	8.4%
Худалдаа наймаа			1669	29.8%
Жижиг дунд үйлдвэрлэл			661	11.8%
Аялал жуулчлал			222	4.0%
Зочид буудал			108	1.9%
Гуанз			448	8.0%
Бусад			1297	23.2%
Нийт			5599	100.0%
Хариулаагүй			-194	-3.5%
Нийт			5405	

Хамгийн их буюу 29.8 хувь нь худалдаа наймаа хийдэг, 11.8 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг, 8.4 хувь нь мал аж ахуйдаа зориулдаг, 8.0 хувь гуанз буюу үйлчилгээ явуулдаг, 6.8 хувь хүнсний ногоо таридаг, 6.1 хувь нь газар тариалан эрхэлдэг, 4.0 хувь нь аялал жуулчлалын бизнест зориулдаг, 1.9 хувь нь зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг байна. Харин 23.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь энэ талаар ойлголт байхгүй эсвэл зээл авах боломжгүй иргэд бололтой (7.4.).

Иргэд маань бичил зээл авч олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэгийг дээр дурьдсан. Харин тэдэнд үйл ажиллагаагаа явуулахад нь хэдий хэмжээний мөнгө хэрэг болдогийг лавлахад 35.4 хувь нь 1.5-2.0 сая төгрөг, 14.7 хувь нь 1.0-1.5 сая төгрөг, 21.6 хувь нь 500 мянгаас 1.0 сая төгрөг, 15.4 хувь нь 250000-500000 төгрөг, 7.5 хувь нь 100000-250000 төгрөг, 5.4 хувь 100000 мянгаас доош төгрөг гэж хариулжээ (7.5.). 2.0 саяаас дээш дүнг хариултанд оруулаагүй учир түүнээс дээш мөнгийг шаардсаныг үгүйсгэхгүй. Хамгийн боломжит хэмжээ нь 1.5-2.0 сая байгааг доорхи хүснэгтээс харж болно.

7.5. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хэдий хэмжээний мөнгө шаардагдах вэ

			2005	
			Хүний тоо	Хувь
100000 доош төгрөг			263	5.4%
100000-250000 төгрөг			365	7.5%
250000-500000 төгрөг			748	15.4%
500000-1 сая төгрөг			1047	21.6%
1-1.5 сая төгрөг			712	14.7%
1.5-2 сая төгрөг			1715	35.4%
Нийт			4850	100.0%
Хариулаагүй			555	11.4%
Нийт			5405	

Бичил зээлийн боломжит мөнгөний хэмжээнийх нь хувьд ийм байдаг байж. Харин хугацааг нь сонирхвол, санал асуулгад хамрагдсан иргэдийн 60.8 хувь нь 9 сараас 1 жил хүртэл, 16.9 хувь нь 6 сараас 9 сар хүртэл, 14.6 хувь нь 3 сараас 6 сар хүртэл, 7.7 хувь нь 3 сар хүртэлх хугацаа шаардлагатай гэжээ (7.6.). Үүнээс үзэхэд бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад хамгийн боломжит хугацаа нь 1 жил орчим байна.

7.6. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар хугацаа шаардагдах вэ

			2005	
			Хүний тоо	Хувь
3 сар хүртэлх			375	7.7%
3-6 сар			712	14.6%
6-9 сар			824	16.9%
9 сараас 1 жил			2967	60.8%
Нийт			4878	100.0%
Хариулаагүй			527	10.8%
Нийт			5405	

Эцэст нь бичил зээл авахад ямар ямар бэрхшээлүүд тулгардагийг сонирхоё. Асуултанд хариулсан иргэдийн 57.8 хувь зээлийн хүү өндөр байна, 10.5 хувь нь зээлийн хэмжээ бага байна, 13.5 хувь нь зээлийн хугацаа хангалтгүй байна, 10.5 хувь нь зээл авах боломж байхгүй байна, 7.8 хувь бусад гэсэн хариултыг өгчээ (7.7.). Эндээс дүгнэж хэлэхэд хүүний түвшин өндөр байгаа нь тэдний үйл ажиллагаанд саад болж байгаа илэрхий байна. Энэ талаар зээлийн хэсэгт дурьдсан тул дахин давтахаас зайлсхийв.

7.7. Бичил зээл авч үйл ажиллагаа явуулахад танд ямар бэрхшээл байна вэ

			2005	
			Хүний тоо	Хувь
Зээлийн хүү өндөр			2800	57.8%
Зээлийн хэмжээ бага			506	10.5%
Зээлийн хугацаа хангалтгүй			652	13.5%
Зээл авах боломжгүй			506	10.5%
Бусад			377	7.8%
Нийт			4841	100.0%
Хариулаагүй			564	11.7%
Нийт			5405	

4. Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлын (санал асуулга) хүрээнд зах зээлийн системд шилжин орсноос хойш өнөөг хүртэл (2005 он) Монгол улсын эдийн засгийн байдал, нийгмийн хурцадсан асуудлууд, татварын тогтолцоо болон ачаалал, банк санхүүгийн салбарын хөгжил үүнээс хадгаламж, зээл, бичил санхүүгийн талаар төв суурин газар болон хөдөө орон нутгийн иргэд маань ямар санал бодолтой байгааг нэгтгэн дүгнэж бодит байдалтай (тоон үзүүлэлтүүдтэй) харьцуулан дүн шинжилгээ хийлээ. Түүний зэрэгцээ 2003 оны судалгаа дээр тулгуурлан иргэдийн санал бодол хэр өөрчлөгдсөнийг харьцуулан дүгнэсэн. Тайлант оны судалгааны ажлын бас нэг онцлог бол санал асуулгад оролцсон иргэдийг орон нутгийн харьяалал, хүйс, нас, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлаар нь бүлэглэн хувааж тус бүрээр нь тайлбар хийсэнд оршино (Хавсралт I-V). Судалгааны ажил нь нийгэм, эдийн засгийн олон чухал асуудлуудыг агуулсан учраас дэлгэрэнгүй тайлбар хийхэд их цаг хугацаа, бусад олон зүйл шаардагдах тул аль болох товчхон оновчтой тайлбар хийсэн болно. Судалгааны ажлын асуулт бүрээр тодорхой хэмжээний тайлбар дүгнэлтүүдийг хийсний зэрэгцээ хавралт болгонд зохих хэмжээний дүгнэлтүүдийг тусгасан учир энэхүү төгсгөлийн хэсэгт дээр ангилсан дэд бүлэг тус бүрээр товчхон дүгнэж цаашид авах арга хэмжээний талаар дурьдсан болно. Эцэст нэмж хэлэхэд энэ судалгааны ажил нь 2004 оны сонгуулийн өмнөх жил буюу 2003 он, мөн сонгуулийн дараахь жил буюу 2005 оныг хамруулж харьцуулсныг анхааралдаа авна уу.

Эдийн засгийн өсөлтийн үр өгөөж иргэдэд хүртэх нь багасаж, үнийн дарамт ихэссэн нь ...

Зах зээлийн системд шилжсэн 1990 оноос хойш 1993 он хүртэл шинэ нийгмийн үндэс суурийг тавих, бүтцийг байгуулах, тэдгээрт хэвшихэд их хүндрэл бэрхшээлүүд учирч байсныг хүн бүхэн санаж байгаа байх. Эдийн

засгийн өсөлт (ДНБ) бараг бүх салбарт сөрөг гарч ерөнхийдөө уналтын байдалд орж байв. Эд барааны хомсдол, үнийн огцом өсөлт, төгрөгийн ханшийн уналт, үндэсний үйлдвэрлэлийн зогсонги байдал, ажилгүйдэл, ядуурал, гадаад худалдааны бууралт зэрэг олон хүндрэл бэрхшээлүүдийг дурьдаж болно. Энэ бүхнийг амжилттай даван туулсны дараа буюу 1994-1999 онуудад эдийн засгийн байдал сэргэж өсөлт нь хэдий тийм өндөр биш (2.3-6.3 хувийн хооронд) боловч өсөлтийн үе эхэлсэн. 2000, 2001 онуудад эдийн засгийн өсөлт өндөр гарах магадлал байсан хэдий ч байгалийн гамшигаас шалтгаалан ДНБ-д өндөр хувийн жин эзэлдэг ХАА-н салбарийн үйлдвэрлэл 14.4-16.0 хувь хүртэл уналтанд орж эдийн засгийн өсөлт 1.1 хувьтай гарсан байна. Харин 2002 онд ХАА-н салбарын уналтын эрч саарсан, тээвэр холбоо, худалдаа үйлчилгээний салбаруудын өсөлт нэмэгдсэнээс үүдэн эдийн засгийн өсөлт 4.0 хувьд хүрчээ. 2003 онд ХАА-н салбарын өсөлт эерэг түвшинд хүрсэн, барилга, санхүүгийн үйлчилгээ, тээвэр, агуулах, холбооны салбарууд огцом өссөний үр дүнд ДНБ-ий өсөлтийг 5.6 хувьд, 2004 онд ХАА-н салбарын өсөлт түргэссэний зэрэгцээ уул уурхай, олборлох үйлдвэрлэл эрчимтэй хөгжсөн нь өсөлтийг зах зээлийн системд шилжин орсноос хойш хамгийн өндөр буюу 10.6 хувьд хүргэжээ. Эдийн засаг макро түвшиндээ тогтворжсон, төсвийн алдагдлыг тууштай бууруулж ирсэн, бизнесийн орчинг дэмжсэн мөнгөний бодлогыг явуулсан, гадаад худалдаа болон гадаад хөрөнгө оруулалтын хамгийн либераль дэглэмийг баримталж ирсэн зэрэг нь төрийн зүгээс эдийн засгийн өсөлтийг хангах хамгийн оновчтой хөрс суурь болж байна. Мөн манай улсын эдийн засагт сүүлийн жилүүдэд хийгдсэн гадаад, дотоод хөрөнгө оруулалт үр өгөөжөө өгч эхэллээ. Харин санал асуулгад оролцсон иргэдийн хариултаас харахад дөрөвний нэг нь л эдийн засгийн байдал сайжирч байна гэж хариулсан нь 2003 оныхоос 13.0 орчим хувиар буурчээ (эсрэгээр, муудаж байна гэсэн нь мөн тэр орчим хувиар нэмэгдсэн). Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт дээшилж улмаар дээд цэгтээ хүрч буй өнөө үед иргэдийн санаа бодол ийнхүү гутрангуй байгаа нь нэгт, үнийн өсөлтийн дарамт иргэдийн ахуй амьдралд нилээд хүнд цохилт өгч улмаар тэр сэтгэлгээгээрээ улсынхаа эдийн засгийг төсөөлсөн; хоёрт, ихэнх иргэдийн бодит орлого (цалин, тэгэвэр, г.м.) дорвитой нэмэгдээгүй, нэмэгдэх бололцоо байгаа эсэх нь тодорхойгүй; гуравт, эдийн засагт бүрэлдэж буй нийгмийн баялаг цөөн тооны хүмүүст төвлөрч байгаа, хуваарилалтынх нь тэгш бус байдал дээд цэгтээ хүрсэн, дөрөвт, гадаадын зуун хувийн хөрөнгө оруулалттай үйлдвэр, пүүс компаниудын үйл ажиллагааны тэлэлт нь ДНБ-ий өсөлтийг өндөр түвшинд хангахад тодорхой хэмжээний үүрэг гүйцэтгэж улмаар Монгол улсын иргэдийн бодит орлогод төдийлөн нөлөө үзүүлж чадахгүй байгаа зэрэгтэй холбоотой байж болох юм гэсэн таамаглалыг төрүүлж байна. Иймд санал асуулгад оролцсон иргэдийн 66.5 хувь (2003 онд иргэдийн 37.9 хувь нь эдийн засгийг сайжирч байна гэж хариулсан) эдийн засгаа сайжраагүй гэж хариу өгсөн нь төр засгийн удирдлагад томхон толгойн өвчин болох учиртай.

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 1999 оноос 2004 он хүртэл тогтмол өсч байгаа хэдий ч харьцангуй доогуур байгаа нь сэтгэл зовоосон асуудал хэвээр байна. 2004 оны байдлаар уг үзүүлэлт 590.4 америк долларт хүрчээ. Хүн амын өсөлт тодорхой хэмжээгээр жилээс жилд явагдах учир түүний өсөлтөөс эдийн засгийн өсөлт хурдацтай явж байж энэ үзүүлэлт өсөх нь тодорхой. Иймд эдийн засгийн өсөлтөө аль болох хурдасгах мөн түүнийг өндөр түвшинд тогтвортой байлгах зорилт бидний өмнө тавигдаж байна.

Санал асуулгад оролцсон иргэдийн бодлоор татварын дарамтыг багасгаж, зээлийн хүүг бууруулан, үндэсний үйлдвэрлэл, бизнесменүүдээ хөхүүлэн дэмжвэл эдийн засгийг хурдацтай хөгжүүлж болно гэж үзжээ. Ялангуяа энэ жил судалгаанд оролцсон иргэд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, зээлийн хүүг бууруулах тал дээр их ач холбогдол өгчээ.

2003 онд ХАА, уул уурхай, олборлох үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбаруудыг эдийн засгийн өсөлтөнд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж хариулж байсан бол энэ онд мөн л ХАА, уул уурхай, олборлох үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарыг дурьдсаны зэрэгцээ боловсруулах үйлдвэрлэлд их ач холбогдол өгсөн байна. Дээр дурьдсан салбаруудаас ХАА-н салбарын дундаж өсөлт (2001-2004) сөрөг, хөдөө орон нутагт амьжиргааны түвшин доогуур, дэд бүтцийн хөгжил сул, дулаан цахилгааны хомсдол, байгалийн хүндрэл бэрхшээлийг даван туулах чадвар бага байгаа зэргээс шалтгаалан иргэдийн ХАА-н салбарт үзүүлэх итгэл 2003 оныхоос 11.0 орчим хувиар буурчээ. Цаашид эдийн засгийн өсөлтийг түргэсгэхийн тулд бусад салбаруудад гарч буй амжилтыг дэмжихийн зэрэгцээ ХАА-н салбарт дорвитой өөрчлөлт хийх шаардлагатай байна гэсэн 2003 оны дүгнэлтийг дахин давтан уламжилъя.

Өргөн хэрэглээний барааны үнийн талаар энэ жилийн судалгаанд оролцсон иргэдийн 90.0 гаруй хувь нь өсч байна гэсэн хариултыг өгчээ. Энэ нь ч аргагүй биз. 2004 оны дунд үеэс эхлэн нефтийн дэлхийн зах зээл дээрх үнэ огцом өсч бензин түлшээ импортоор хангадаг манай улсын хувьд үнийн дарамтанд орсон мөн дотоодын нийлүүлэлтийн хомсдол зэрэг нь бензин шатахууны үнийг хөөрөгдөж улмаар хэрэглээний барааны үнийг өсгөхөд хүргэсэн байна. Түүний зэрэгцээ дотооддоо зарим нэг хэрэглээний гол бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх ажил хангалтгүй явагдсан нь үнийн өсөлтөнд нөлөөлжээ. Дээрх шалтгаануудын улмаас инфляцийн жилийн түвшин 2004 оны 8-р сараас эхлэн хоёр оронтой тоонд шилжин оны эцэст зорилтот түвшиндээ хүрч чадсангүй. Улмаар энэ бүхний үр дагавар үргэлжлэн 2005 оны 8-р сар хүртэл (өнөөг) хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсээр байна. Хэрэв нефтийн үнэ дахин огцом өсөхгүй, хэрэглээний гол бараа бүтээгдэхүүнүүдийг бэлтгэн нийлүүлэх ажлыг төрийн оролцоотойгоор зөв удирдан хийж чадвал эргээд бид инфляцийг нэг оронтой тоонд бүрэн барьж чадах найдвар байна. Монголбанк энэ хариултаас өнөөг хүртэл явагдаж өнгөрсөн инфляцийн өсөлтөөс илүүтэйгээр нийгэмд инфляцийн хүлээлт бий болжээ гэдэг бодлогын дүгнэлтийг өөртөө хийж байна. Инфляцийн хүлээлтийг эргэн нэг оронтой тоонд авчрахын тулд Хэрэглээний Үнийн Индексийг 2-3 жил дараалан жилийн 10 хувиас доор түвшинд барих Төв банкуудын жишиг байдаг. Нөгөө талаас 2004-2005 онуудын инфляцийг хөөрөгдсөн гол хүчин зүйлс нь гол төлөв нийлүүлэлтийн шокоос үүдэлтэй байсан нь мөнгөний бодлогыг хатууруулах хэмжээ, цар хүрээ болон хугацааны хувьд Монголбанк болгоомжтой хандах нөхцөл болж ирсэн.

Иргэдийн бодлоор амьжиргааны түвшин доошилж, ядуурал, ажилгүйдэл ихэссээр л ...

Судалгаанд оролцсон иргэдийн зүгээс өнөөгийн эдийн засгийн байдалд тааламжгүй үнэлгээ өгсний зэрэгцээ өрхийн амьжиргааны түвшин

доошилсон, хүн амын ядуурал нэмэгдсэн, ажилгүйчүүдийн тоо ихсэж байна гэж сэтгэл дундуурхан хариулжээ. Эдийн засаг нь өсч (ДНБ сүүлийн жилүүдэд огцом өссөн, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ харьцангуй нэмэгдсэн) байгаа үед иргэдийн амьдрал дагаад бага ч гэсэн дээшлэх ёстой. Харин энэ оны судалгаагаар эсрэг гарсан нь судлаачид бидний сонирхолыг ихэд татаж байна. Үүнд тайлбар хийхэд багагүй цаг хугацаа, хүндрэл бэрхшээлүүд учрах бөгөөд юуны түрүүнд тоон мэдээллүүдийг дахин нэг харж тунгаан бодъё.

ҮСГ-аас гаргадаг статистикийн тоон үзүүлэлтээс харахад ажилгүйчүүдийн тоо болон түвшин 2002 оноос эхлэн өнөөг хүртэл бага зэрэг өссөн байна. Ажиллах хүчнээ гадаадад тогтмол тодорхой хэмжээгээр гаргаж байгаа, дотооддоо олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр ажлын байр нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлж байгаа мөн төр засгаас ч олон төрлийн арга хэмжээ авч байгаа хэдий ч ажилгүйчүүдийн тоо дорвитой багасахгүй харин ч сүүлийн жилүүдэд өсөх хандлага ажиглагдаж байна. Энд нэг зүйлийг анхааруулж хэлэхэд жижиг худалдаа наймаа хийж өөрсдийгөө авч явж байгаа иргэдийг ямар ангилалд оруулж байгааг тодорхой болговол ажилгүйчүүдийн тоо арай бодитойгоор гарах болов уу. Түүний зэрэгцээ өөрсдөө идэвхтэй ажил хөдөлмөр хайж хөөцөлдөхгүй, ажиллах сонирхол хүсэлгүй хүмүүс байгааг ч үгүйсгэхгүй. Төр засгаас ажил идэвхтэй хайж байгаа иргэдэд ажлын байр бий болгох тал дээр бодлогын том алхам хийх шаардлагатай байгаагийн зэрэгцээ дээр дурьдсан хүмүүст анхаарал тавин хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй байна. Ялангуяа хувиараа хөдөлмөр эрхлэх орчныг нь бүрдүүлж өгөх, түүнийгээ сурталчлан нийгмийг хамруулах нь өнөөгийн чухал тулгамдсан асуудал хэвээр байна.

Манай улсын эдийн засгийн дундаж өсөлт тийм ч өндөр биш, нэг хүнд ногдох орлогын түвшин доогуур байгаа нь ядуу орнуудын тоонд зүй ёсоор орж байна. Мөн нийгмийн орлогын хуваарилалтын тэгш бус байдал болон ядуучуудын түвшин (өдрийн нэг ам. доллараас доош орлоготой) өндөр байгаа нь үүний нэг нотолгоо юм. Энэ талаар ч санал асуулгад оролцсон иргэдийн ихэнх нь санал нэгтэй байсан. Ядуурлаас ангижрах нь тийм ч амар хурдан шийдвэрлэх асуудал биш гэдэг нь бусад улс орнуудын түүхэн замнал харуулж байна. Харин түүнийг яаж газар авахуулахгүйгээр зогсоох, цаашид багасгах арга хэмжээг цаг алдалгүй авах нь чухал юм. Манай улсын хувьд ОУВС-гаас ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж эхлээд 15 жил болсон, мөн дээр дурьдсанчлан иргэдэд хувиараа хөдөлмөр эрхлэх орчин болон боломжийг бүрдүүлж өгвөл зөвхөн ядуурал буурахаас гадна ажилгүйчүүдийн эгнээнд байгаа хүмүүсийн тоо ч цөөрнө. Үүнийг дагаад өрхийн орлого ч нэмэгдэх болно шүү дээ.

Иргэд маань өөрийн тодорхой хэмжээний газартай болох нь өрхөд нь болон амьдралд нь их ашиг тус үзүүлнэ. Үүнийг ч тэд сайн ойлгож эхэлсэн нь 2003 онтой харьцуулахад газар хувьчлалыг ихэнх нь дэмжсэнд оршино. Энэ үйл ажиллагааг хууль зүйн хүрээнд шударга зөв явуулж чадвал нийгмийн бусад эмзэг асуудлуудыг бага боловч шийдвэрлэж болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Капиталын хувьд эрчимтэй (capital intensive) уул уурхайн чиглэлийн цөөхөн төслөөр хангагдсан Латин Америкийн орнуудын эдийн засгийн

өсөлт нь хүн амын дийлэнхид² огт үр өгөөжөө авчраагүй туршлага байдаг. Өсөлтийн үр өгөөж нийгэмд хэт нэг талыг барин хуваарилагдаж байна гэсэн дүгнэлт энэ санал асуулгаас хийгдэхээр байна.

Татварын түвшин өндөр, ачаалал нь их хэвээр л ...

Татварын ачаалал 1999 оноос хойш тогтмол нэмэгдсээр 2004 оны байдлаар ДНБ-ий 32.0 хувийг³ эзэлж байна. Судалгаанд оролцсон иргэдийн хариултаас харахад татварын ачаалал их байна мөн татвараас зайлсхийх явдал түгээмэл байна гэсэн хариултуудын хувь 2003 оныхоос бага зэрэг буурсан ч иргэдийн дийлэнх (66.5-74.7 хувь нь) татварын ерөнхий түвшин өндөр, ачаалал нь сүүлийн жилүүдэд улам нэмэгдэж байгаа, татвараас зайлсхийх явдал нийтлэг болсон гэж үзсэн хэвээр байна. Мөн татварын дарамт эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлж байна (25.5 хувь) гэж хариулсныг санаж байгаа байх. Иймээс татварын дарамтыг багасгаж, уян хатан бодлого болон тогтолцоог бий болгох тал дээр арга хэмжээ авах цаг нь болжээ гэсэн 2003 оны дүгнэлтийг дахин давтаж хэлмээр байна. Тухайлбал, хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага бүрт ногдох татварын хэмжээг ерөнхийд нь бууруулан татварт хамрагдахгүй байгаа, татвараас зайлсхийж буй хуулийн этгээдүүдийг бүрэн хамруулж төсвийн орлогыг бүрдүүлэх хэрэгтэй байна. Ингэхийн тулд өргөн хүрээтэй олныг хамруулсан шуурхай ажлыг тогтмол зохион явуулах, зар сурталчилгааны үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлэх, тогтмол татвар төлөгчдөд зохих хэмжээний урамшуулал хөнгөлөлт үзүүлж түүнийгээ сурталчлах (зөвхөн нэг удаагийн баярын бичиг, мөнгөн хөрөнгөөр шагнаад зогсохгүй), татвараас зайлсхийгчдэд хуулийн хатуу хариуцлага тооцох, түүний хууль зүйн орчинг боловсронгуй болгох, бусад орнуудын туршлагыг судалж өндөр мэдлэгтэй боловсон хүчин бэлдэх зэрэг олон ажлыг цаг алдалгүй хийх шаардлагатай байна. Татвар өндрөөс аж ахуйн нэгжүүд тайлан тэнцлээ худал гаргадаг нь эргээд банкууд зээлийн эрсдэлээ үнэн зөв дүгнэхэд хүндрэл учруулан зээлийн хүүг бууруулахад сөргөөр нөлөөлдөг. 2005 оны эцсээр татварын багц хуульд оруулж буй нэмэлт, өөрчлөлтүүд батлагдвал энэ бүхэнд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт найдвар тавих л үлдлээ.

Банкны салбарын үйл ажиллагаа сайжирч, түүнд итгэх иргэдийн итгэл дээшилсээр л ...

Санал асуулгад оролцсон иргэдийн ихэнх нь банк санхүүгийн салбар эрүүлжиж санхүүгийн зуучлал гүнзгийрсэн, зээлийн хэмжээ ихсэж эдийн засаг дахь хөрөнгө оруулалт нэмэгдсэн, хадгаламжийн хэмжээ өсч банкинд итгэх итгэл дээшилсэн, хүүний түвшин харьцангуй буурсан, төлбөр тооцоо түргэн шуурхай болохын зэрэгцээ төлбөрийн шинэ дэвшилтэт хэлбэр болох картан үйлчилгээ нэвтэрсэн зэрэгтэй санал нэг байна.

Тэдний бодлоор өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй банкуудын (ББСБ-ын тоог оруулж тооцсоныг үгүйсгэхгүй) тоог 2003 оны хариулттай харьцуулахад олон байна гэж үзсэн хэдий ч ихэнх нь боломжийн гэж дүгнэсэн байна. Түүний зэрэгцээ банкны үйл ажиллагаанд эргэлзэх эргэлзээ нь буурсан, итгэх итгэл нь дээшилсэн, банкуудын үйл

² Боливи, Перугийн 1970-80-д онуудын хөгжлийн загвар

³ Татвар/ДНБ-ний харьцаа

ажиллагаа түргэн шуурхай болж хувь хүнд хүрч чадаж байна гэж хариулжээ. 2005 оны 8-р сарын 31-ний байдлаар 17 банк үйл ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ 137 банк бус санхүүгийн байгууллага, мөн хэдэн зуун хадгаламж зээлийн хоршоо, ломбардууд санхүүгийн ажиллагаа эрхэлж байна. Энэ нь урд өмнө байгаагүй банк санхүүгийн салбарын өргөн тэлэлт, том үсрэлт юм. Өргөжиж олшрохын зэрэгцээ өрсөлдөөн бий болно. Өрсөлдөөн нь харилцагчдыг хэрхэн татаж яаж үйлчлэхийг сургаж өгнө. Нөгөө талаас банк санхүүгийн байгууллагууд өөрсдийн харилцагчдаа алдахгүйн тулд аль болох түргэн шуурхай үйлчилгээ явуулж, найдвартай үйл ажиллагаа эрхэлнэ. Энэ бүхний үндсэн дээр харилцагчдын итгэл дээшилж банк санхүүгийн байгууллагаар тогтмол үйлчлүүлнэ. Өнөөгийн байдлаар манай улсад иймэрхүү л үйл явдал өрнөж байна. Харин цаашид үүнийгээ хадгалахын зэрэгцээ улам боловсронгуй болгож бүх нийтийг хамруулах шаардлагатай байна. Ялангуяа иргэдийн эргэлзээ бүрэн арилаагүй (урьдын хямралын сургамж бүрэн мартагдаагүй), зарим иргэд банк санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлж үзээгүй буюу мэдэхгүй ийм үед мэдээлэл, сурталчилгаа, сургалт их үүрэг гүйцэтгэх болно.

Иргэдэд мөнгөний хэрэгцээ гарвал хамгийн түрүүнд хувь хүмүүст (найз нөхөд болон дотны хүмүүс) ханддаг, мөн хамгийн амрыг бодож ломбардыг зоридог байдал арилж байгаа нь 2003, 2005 онуудын хариултаас харагдаж байна. Судалгаанд оролцсон иргэдийн тал орчим хувь нь мөнгөний хэрэгцээ гарвал банк уруу хандана гэж хариулжээ. Хувь хүн, ломбард гэсэн хариултууд багагүй хувийг (21.2 ба 15.6 хувь) эзэлж байгаа ч иргэд маань банкаар үйлчлүүлж эхэлж байгаа нь дээрх хариултаас харагдаж байна.

Харин ББСБ-ын талаар тааруухан ойлголттой тул бараг үйлчлүүлдэггүй хэвээр байна. Яваандаа банкуудын хэмжээ томрон үйл ажиллагаа нь өргөжих үед бичил банкны үүргийг дээрх байгууллагууд гүйцэтгэнэ. Иймээс зөвхөн банкууд биш ББСБ-ууд өөрсдийн үйл ажиллагаагаа сайн сурталчилж, аль болох өргөн хүрээтэй үйлчилгээг олон нийтийн дунд явуулж, санхүүгийн зуучлагчийн үүргээ гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Хөдөө орон нутагт ББСБ-ын үйл ажиллагаа төдийлөн хөгжихгүй байгааг удирдах байгууллагууд анхааралдаа авна уу.

Судалгаанд оролцсон иргэдийн 10.0 гаруй хувь нь ХЗХ-ны гишүүн, тал орчим хувь нь түүний үйл ажиллагааны талаар ойлголттой байсан бөгөөд харин үйл ажиллагаа нь хэрхэн явагдаж байгааг ихэнх нь мэдэхгүй байлаа. Өнөөгийн байдлаар 570 гаруй ХЗХ бүртгэлтэй байгаагаас хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг нь тун цөөн байна. Хадгаламжийн өндөр хүү зарлан иргэдийн хөрөнгийг татан төвлөрүүлчихээд хугацаанд нь төлөхгүй, улмаар огт төлөхгүй байгаа байдал нилээд газар авсан байна. Түүгээр ч барахгүй гэмт хэргийн буюу залилангийн шинж чанартайгаар ХЗХ-г ашиглаж байгаа нь туйлын харамсалтай байна. Иймээс төр засгаас ХЗХ-ны асуудлыг зөв зам уруу нь оруулахын тулд хууль зүйн орчинг нь чангатгаж өгөх, тогтмол хянаж шалгаж байдаг бие даасан нэгжийг бий болгох, тэдний талаар тоон буюу бусад мэдээллийг цуглуулан авч зохих байгууллагаар шалгуулан нийтэд мэдээлж байх шаардлагатай байгааг анхааралдаа авна уу.

Иргэдийн санал бодлоор манай улсын эдийн засагт дотоодын эх үүсвэрээс гадна гадаадын хөрөнгө оруулалттай банкууд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзжээ. Энэ нь эдийн засагт орох хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэн, банк санхүүгийн салбарын өрсөлдөөнийг бий болгож, үйл ажиллагааг нь улам боловсронгуй болгох сайн талтай бөгөөд харин улсынхаа зах зээлийн багтаамж, учруулж болзошгүй эрсдэлийг тооцоолон хэмжээ тоог нь хязгаарлах зөв юм.

Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох картыг хэрэглэдэг иргэдийн тоо 2003 оныхоос 10.0 орчим хувиар нэмэгдсэн хэдий ч урьд онуудын адил ихэнх нь нь хэрэглэдэггүй улмаар ойлголт байхгүй хэвээр байна.

Ихэнх иргэдэд хадгалуулах мөнгө байхгүй, ... мөнгөтэй нь бэлнээр мөн төгрөгөөр байлгахыг л тэмүүлсээр ...

Манай улсын иргэдийн бодит орлого бага учир ихэнхэд нь хэмнэх гардаггүй байна. Хэмнэх мөнгөтэй буюу хэмнэх мөнгө байсан тохиолдолд банкинд хадгалуулах эсвэл худалдаа наймаа хийж эргэлдүүлэх болно гэж иргэдийн ихэнх нь урьд онуудын адил хариулсан байна. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүд эрчимтэй нэвтэрч байгаа (ихэвчлэн хүн ам төвлөрсөн газруудад) энэ үед иргэдийн дийлэнх нь мөнгөө бэлнээр байлгах сонирхолтой байгаа нь дээрх хэрэгсэл нь нийт нутаг дэвсгэрийг бүрэн хамарч чадаагүй (үүнд нилээд хугацаа шаардагдана), иргэдийн бодит орлого бага учир ихэнх нь өдрийн амь зугаах хэдэн төгрөгийг бэлнээр авч явдаг, татварын бодлого болон тогтолцооны буруу үйл ажиллагаанаас шалтгаалан татвараас зайлсхийхийн тулд мөнгөө бэлнээр байлгадагтай холбоотой байж болох юм. Мөн нэмж хэлэхэд санхүүгийн зах зээлийн хөгжил дорой тул түүнд хөрөнгөө байршуулах боломжоор тун хомс байдаг нь ажиллагдаж байна. Харин банкинд мөнгөө хадгалуулахдаа төгрөгийг илүүд үзэж байгаа нь төгрөгийн ханшны уналт харьцангуй багасаж тогтворжсон, төгрөгийн хадгаламжийн хүү өндөр, төгрөгийн бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл нэвтэрч эхэлсэн, сүүлийн үед дэлхийн гол валют болох америк долларын ханш харьцангуй тогтвортой биш байгаатай холбоотой болов уу. Мөн хөдөө орон нутагт төгрөгийн үйлчилгээ зонхилж байгаатай ч уялдаатай. Хадгаламжийн бодит хүү сүүлийн жилүүдэд эерэг түвшинд байгаа хэдий ч энэ жилийн санал асуулгаар иргэдийн ихэнх нь хадгаламжийн хүүг бага байна гэж хариулжээ.

Зээлийн эрэлт их, хүү нь өндөр хэвээр л ...

Сүүлийн үед банк санхүүгийн салбар өргөжин тэлэхийн зэрэгцээ зээлийн хэмжээ, тоо, төрөл нэмэгдсэн хэдий ч иргэдийн хувьд эрэлт нь урьдын адил өндөр хэвээр байна (2003 оны түвшинд буюу 80 гаруй хувь). Харин банк санхүүгийн байгууллагуудаас олгож буй зээлийн хүртээмж 2003 оныхоос 10.0 орчим хувиар нэмэгдсэн нь тэдний эрэлтийг бага боловч хангаж байгаатай холбоотой юм. 2003 онтой харьцуулахад зээл авахад хүндрэлгүй гэж хариулсан иргэдийн тоо 6.0 хувиар өссөн ч хүндрэлтэй гэж хариулсан иргэд олонхи хэвээр байна. Зээлийн хүүг урьдын адил өндөр байна гэж тэдний ихэнх нь үзэж байгаа нь 2003 оныхоос 10.0 орчим хувиар өсч 70.0 хувь болсноор тайлбарлагдаж байна. Мэдээж зээлийг хүссэн хүн

болгон авч чадахгүй. Зээл бол тусламж биш. Барьцаа хөрөнгө, бизнес төлөвлөгөө зэрэг эргээд олгосон газарт учруулж болзошгүй эрсдэлээс сэрэмжилсэн олон зүйл шаардагдана. Иймээс иргэдийн зүгээс өөрсдийгөө болон зээл олгож буй байгууллагаа эрсдэл оруулахгүй байхын төлөө энэ үйл ажиллагаанд оролцох нь хэрэгтэй юм. Хүүний хувьд өндөр байгаатай санал нэг байна. Энэ нь эргээд өөрсдөд (зээл олгож буй байгууллага) нь эрсдэл учруулж болзошгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Цаашид бууруулах тал дээр анхааран ажиллаж байгаа бөгөөд хэмжээ, хугацаа, зориулалтаас хамааран янз бүр байна гэдгийг нэмж хэлэхэд илүүдэхгүй болов уу.

Бичил санхүү иргэдийн амьжиргааны баталгаа болсоор л ...

Бичил санхүүгийн үйл ажиллагаа илт хөгжиж буй өнөө үед санал асуулгад оролцсон иргэдийн дийлэнх нь түүний талаар ойлголттой, оршин суугаа газар нь тодорхой хэмжээгээр хөгжсөний зэрэгцээ 60.0 орчим хувьд нь бичил зээл авах боломж байдаг байна. Иргэдийн ихэнх нь бичил авчихаад худалдаа наймаа хийх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, мал аж ахуй болон үйлчилгээний зориулалтаар ашигладаг байна. Ийм хэв маягийн үйл ажиллагаа явуулахад тэдэнд ихэнх дохиолдолд 500 мянгаас 2 сая хүртэлх төгрөг, нэг жил орчим хугацаа шаардлагатай байдаг бөгөөд зээлийн хүү өндөр байгаа нь тэдний гол бэрхшээл болж байна. Манай улс шиг хүн амын ядуурал ихтэй газар бичил санхүүгийн үйл ажиллагаа нь ихэнх иргэдийн амьдралд тус дөхөм болж, тэднийг хувиараа хөдөлмөр эрхлэх, улмаар өрхөө авч явахад нь дэм дэмжлэг болж байна. Түүгээр ч барахгүй бичил зээл дээр тулгуурлан босч дунд болон том бизнест хөл тависан иргэд байгааг ч үгүйсгэхгүй. Төр засгаас ч бичил санхүүгийн үйл ажиллагааг их дэмжиж байгаа нь тун сайшаалтай хэрэг. Цаашид бичил санхүүгийн үйл ажиллагааг улам дэлгэрүүлж, бичил зээлийн хэмжээ болон хугацааг бага боловч нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүүг нь тодорхой хэмжээгээр бууруулж өгвөл ядуурлаас гарах, ажилгүйдлийг тоог багасгах, эдийн засгийн өсөлтийг хангах төр засгийн бодлогод бага боловч хувь нэмэр оруулах болно.

Энэ судалгааны ажил нь хэдий маш товч боловч их өргөн хүрээг хамарснаараа ач холбогдолтой боллоо. Үүний зэрэгцээ Хавсралт I-V-д иргэдийг харъяалал, хүйс, нас, боловсрол, ажил эрхлэлтийн байдлаар ангилан, бүлэг тус бүрээр нь тайлбар, дүгнэлт хийсэн нь та бүхний сонирхолыг илүүд татна гэдэгт найдаж байна. Дараа дараагийн судалгааны ажлуудаа (санал асуулга) тухайн үеийн тулгамдсан асуудал тус бүрээр нь тусад нь хийж та бүхний сонорт хүргэнэ. Эцэст нь судалгааны ажилд идэвхтэй оролцсон МУИС-ын Социологийн тэнхим, Монголбанкны МБСГ-ын хамт олонд талархсанаа илэрхийлье.

МОНГОЛБАНК